



ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

НИЙЦЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

**“ОРОН НУТАГТ ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХ ҮЙЛ АЖИЛЛАГААНД
МӨРДӨГДӨЖ БАЙГАА ДҮРЭМ ЖУРМЫН ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН”**

**ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ БҮХИЙ БАЙГУУЛЛАГУУДТАЙ ХАМТАРЧ
АЖИЛЛАХ, ТЭДГЭЭРИЙН ХУУЛИАР ХҮЛЭЭСЭН ҮҮРГИЙН
БИЕЛЭЛТИЙГ ХАНГУУЛАХ ШААРДЛАГАТАЙ БАЙНА.**

Аудитын код: ДГА-2020/02/НА

Цахим хуудас:
www.dornogovi.audit.mn

Дорноговь аймаг
2020 оны 07 сар

Дарга, тэргүүлэх аудитор: Ч.Ариунаа

Утас: 70522734

Цахим хаяг: dornogovi@audit.gov.mn

Аудитын менежер: Ч.Хэрлэнчимэг

Утас: 70523020

Цахим хаяг: kherlenchimegch@audit.gov.mn

Ахлах аудитор:

Ц.Лүндэгмаа

Цахим хаяг: lundegmaa.ts@audit.gov.mn

Аудитор:

Т.Мөнхтогтох

Цахим хаяг: munkhtogtokht@audit.gov.mn

Гэрээт аудитор:

З.Давааням

Цахим хаяг: zagdaadavka@gmail.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

Товчилсон үгийн тайлбар	3
Хүснэгтийн товъёог	4
Графикийн товъёог	4
Зургийн товъёог	4
Аудитын зорилт, хамарсан хүрээ, стандарт, арга зүйн талаарх мэдэгдэл	5
Ерөнхий мэдээлэл	6
Бүлэг 1. Аж ахуйн үйл ажиллагааны тухай хуулийн шаардлагад нийцүүлж тусгай зөвшөөрөл олгох хэрэгтэй байна	8
1.1 Тусгай зөвшөөрөл олгоход баримтлах зарчим, шаардлагыг хангалтгүй хэрэгжүүлсэн байна	8
1.1.1. Аж ахуйн тусгай зөвшөөрөл бүхий байгууллагуудын үйл ажиллагааны үр дүнд чиглэсэн бодлого, зорилго, зорилт дэвшүүлсэн хэдий ч үр дүн хангалтгүй байна	8
1.1.2. Аймгийн ИТХ-аас хуулийн хязгаарт багтаан тэмдэгтийн хураамжийг тогтоосон хэдий ч хэрэгжилтийг хянах үйл явц хангалтгүйгээс тэмдэгтийн хураамж дутуу төвлөрүүлсэн байна	9
1.1.3. Нийгэмд учрах эрсдэл, бодит хэрэгцээ зэргийг судлаагүй, зөвхөн хууль эрхзүйн шаардлага хангасан тохиолдолд тусгай зөвшөөрөл олгосон байна	12
1.1.4. Тусгай зөвшөөрөл олгох нормативт хэмжээг баталсан эрх зүйн актад нийцүүлж үйл ажиллагаа явуулаагүй байна	13
1.2. Тусгай зөвшөөрөл бүхий байгууллагууд хууль, тогтоомж, стандартын шаардлагыг бүрэн хэрэгжүүлж ажиллаагүй, стандартад нийцүүлж тохирлын гэрчилгээ олгоогүй байна	14
1.2.1. Хариуцсан албан тушаалтан болон ААНБ-ын хариуцлагагүй байдлаас шалтгаалж тусгай зөвшөөрөл олгохтой холбоотой хууль эрхзүйн актын хэрэгжилт хангалтгүй байна	14
1.2.2. Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрөл бүхий байгууллагуудад мэргэжлийн боловсон хүчин дутмаг, санхүүгийн чадавх сул, материаллаг байдал хангалттай бүрдээгүй байна	16
1.3. Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн бүртгэлийг сайжруулж олон нийтэд ил тод мэдээлэх хэрэгтэй байна	18
1.3.1. Архи, тамхины тусгай зөвшөөрлийн хугацаа, хөдөлгөөн өөрчлөлт, тусгай зөвшөөрөл эзэмшигчийн гаргасан зөрчлийг нэгтгэн хянаж бүртгээгүй байна	18
1.3.2 Тусгай зөвшөөрөлтэй холбоотой үйл ажиллагааны талаар ил тод мэдээлэх хэрэгтэй байна	21
Бүлэг 2. Тогтоосон шаардлага, стандарт баримтлаагүй байгууллагуудтай ажиллах арга барилаа өөрчилж хууль эрх зүйд нийцүүлж ажиллах шаардлагатай байна	22
2.1. Тусгай зөвшөөрөл эзэмшигчид аж ахуйн үйл ажиллагаанд мөрдөх шаардлагуудыг биелүүлээгүй байна	22
2.1.1. Аж ахуйн үйл ажиллагаанд стандарт, дүрэм журмыг хэрэгжүүлээгүй байна	22
2.1.2. Тусгай зөвшөөрөл эзэмшигчид хуулиар хүлээсэн үүргээ биелүүлээгүй байна	24
2.2. Тусгай зөвшөөрөл бүхий ААНБ-д хяналт хэрэгжүүлж байгаа хэдий ч тэдгээрийн хариуцлагагүй байдал, хууль эрх зүйн мэдлэг дутмагаас зөрчил арилахгүй байна	26
2.2.1. Шаардлага хангаагүй бүх цэгүүдэд тусгай зөвшөөрлийг хүчингүй болгож дорвитой арга хэмжээ аваагүйгээс хяналтаар илэрсэн зөрчилд өгсөн зөвлөмж хэрэгжихгүй, хяналт шалгалтын үр дүнг хангалтгүй болгож байна	26
2.2.2. Байгууллагууд тусгай зөвшөөрлийн хугацаандаа стандарт дүрэм журмаа мөрдөж, хяналтаар өгсөн зөвлөмжийг тууштай хэрэгжүүлэх хэрэгтэй байна	28
Дүгнэлт:	30
Зөвлөмж:	31
Холбогдох байгууллагаас ирүүлсэн санал:.....	32
Саналд өгсөн тайлбар:	35

Товчилсон үгийн тайлбар

ААН	Аж ахуйн нэгж
ААНБ	Аж ахуйн нэгж байгууллага
ААҮАТЗТХ	Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хууль
АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
АЗДТГ	Аймгийн Засаг даргын Тамгын газар
АИТХ	Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
АИТХТТ	Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тэргүүлэгчдийн тогтоол
АМГТГ	Ашигт малтмал газрын тосны газар
БГ	Боловсролын газар
БОАЖГ	Байгаль орчин, аялал жуулчлалын газар
БОМТ	Байгаль орчны менежментийн төлөвлөгөө
БСШУС	Боловсрол соёл шинжлэх ухааны сайд
ЗГ	Засгийн газар
ЗД	Засаг дарга
ЗДТГ	Засаг даргын Тамгын газар
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
ИТХТ	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тэргүүлэгч
ЕБ	Ерөнхий боловсрол
ЕБС	Ерөнхий боловсролын сургууль
МХБ	Мэргэжлийн хяналтын байгууллага
МХГ	Мэргэжлийн хяналтын газар
МХЕГ	Мэргэжлийн хяналтын Ерөнхий газар
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
НӨАТ	Нэмэгдсэн өртгийн албан татвар
ОНЕО	Орон нутгийн ерөнхий орлого
ОНӨААТҮГ	Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар
ӨЭМТ	Өрхийн эрүүл мэндийн төв
СХЗХ	Стандарт хэмжил зүйн хэлтэс
СӨБ	Сургуулийн өмнөх боловсрол
СӨБТХ	Сургуулийн өмнөх боловсролын тухай хууль
ТҮИХҮХТЖ	Тамхины үйлдвэрлэл, импорт, худалдаа, үйлчилгээнд хяналт тавих журам
ТТАМ	Түгээмэл тархацтай ашигт малтмал
ТХТХ	Тамхины хяналтын тухай хууль
УТХТХ	Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хууль
УТХ	Улсын тэмдэгтийн хураамж
ХАА	Хөдөө аж ахуй
ХБИ	Хөгжлийн бэрхшээлтэй иргэн
ХОХБХ	Хөрөнгө оруулалт хөгжлийн бодлогын хэлтэс
ХХАА	Хүнс хөдөө аж ахуй
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
ЭМБ	Эрүүл мэндийн байгууллага
ЭМГ	Эрүүл мэндийн газар
ЭМТ	Эрүүл мэндийн төв
ЭМСС	Эрүүл мэнд, спортын сайд
ЭХНТ	Эм ханган нийлүүлэх төв
ЭЭС	Эм эргэлтийн сан
ЯТТ	Яаралтай түргэн тусламж

Хүснэгтийн товъёог

№	Тайлбар	Хуудасны дугаар
Хүснэгт 1	Эрүүл мэндийн байгууллагын тусгай зөвшөөрөл	6
Хүснэгт 2	Сургууль, цэцэрлэгийн тусгай зөвшөөрөл	6
Хүснэгт 3	ТТАМ хайх, ашиглах тусгай зөвшөөрөл	7
Хүснэгт 4	Согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрөл эзэмшигч	7
Хүснэгт 5	Түгээмэл тархацтай ашигт малтмал ашиглах тусгай зөвшөөрөл	10
Хүснэгт 6	Түгээмэл тархацтай ашигт малтмал хайх тусгай зөвшөөрөл	10
Хүснэгт 7	Согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрөл олгоход хураах УТХ	11
Хүснэгт 8	ТТАМ ашиглах, хайх тусгай зөвшөөрлийн шийдвэрлэлт	18
Хүснэгт 9	Согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрлийг хүчингүй болгосон, дахин шинээр олголт	19
Хүснэгт 10	Тамхины тусгай зөвшөөрлийг сунгахдаа хугацаа хэтрүүлсэн хоног	20

Графикын товъёог:

№	Тайлбар	Хуудасны дугаар
График 1	Тамхины тусгай зөвшөөрлийн тоо	12
График 2	СӨБ-д хамрагдаагүй хүүхдийн тоо	12

Зургийн товъёог:

№	Тайлбар	Хуудасны дугаар
Зураг 1-2	Сайншанд сумын ЗДТГ-ын цахим хуудас	22
Зураг 3-4	ЕБС-ийн хичээлийн болон дотуур байрнаас 500 метрийн доторх зайг тодорхойлсон зураглал	23
Зураг 5-6	Тамхийг тусгайлсан лангуугаар худалдаалахгүй кассын дэргэд байрлуулсан	24

Аудит үндэслэл, эрх	Дорноговь аймаг дахь Төрийн аудитын газрын 2020 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний дагуу “Орон нутагт тусгай зөвшөөрөл олгох үйл ажиллагаанд мөрдөгдөж байгаа дүрэм журмын хэрэгжилт, үр дүн” сэдэвт нийцлийн аудит хийлээ.
Аудитын зорилт	Орон нутагт тусгай зөвшөөрөл олгох үйл ажиллагаанд мөрдөгдөж байгаа дүрэм журмын хэрэгжилт үр дүнд нийцлийн аудит хийж, дүнг холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулахад аудитын зорилт чиглэгдэнэ. Аудитын дэд зорилтыг хангахын тулд дараах чиглэлээр аудит хийнэ. Үүнд: -Хуульд нийцүүлж тусгай зөвшөөрөл олгосон эсэх; -Тусгай зөвшөөрөл эзэмшигч хууль тогтоомж, эрх зүйн актаар тогтоосон шаардлагыг сахин биелүүлсэн эсэх.
Аудитын хамарсан хүрээ	Аудитаар архи, согтууруулах ундаа, тамхины тусгай зөвшөөрөл, эрүүл мэндийн тусгай зөвшөөрөл, түгээмэл тархацтай ашигт малтмал ашиглах тусгай зөвшөөрөл, боловсролын тусгай зөвшөөрөл бүхий аж ахуйн нэгж байгууллагууд, аймаг, сумын ЗДТГ, ИТХ, ЭМГ, БГ, БОАЖГ, Цагдаагийн газар, МХГ зэрэг байгууллагуудын 2017-2019 оны тусгай зөвшөөрөл олгохтой холбоотой үйл ажиллагааг хамрууллаа.
Аудитын арга зүй, шалгуур үзүүлэлт	Аудитыг гүйцэтгэхэд ТХШС, Нийцлийн аудитын удирдамж, нийцлийн аудитын түр журмыг ашиглах, холбогдох байгууллага, албан тушаалтнуудтай ярилцлага хийх, асуулга лавлагаа, тодруулга авах, тусгай зөвшөөрөл олгох үйл ажиллагаатай холбоотой бусад шаардлагатай баримт материалд тулгуурлан дүн шинжилгээ хийх бөгөөд аудитын хөтөлбөр, горим, асуудлын шинжилгээ, шалгах хуудасны дагуу нотлох зүйл цуглуулж, аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж боловсруулав.
Аудитын бүрэлдэхүүн, хугацаа	Аудитыг Дорноговь аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Ч.Ариунаа удирдаж, үе шатны хяналтыг аудитын менежер Ч.Хэрлэнчимэг хэрэгжүүлж, ахлах аудитор Ц.Лүндэгмаа, аудитор Т.Мөнхтогтох, гэрээт аудитор З.Давааням нар гүйцэтгэв. Аудитын төлөвлөгөөг 2020 оны 05 дугаар сарын 15-нд батлуулж, талбарын ажлыг 2020 оны 06 дугаар сарын 15-ны өдөр хүртэл, аудитын тайланг 2020 оны 06 дугаар сарын 24-ний дотор бичиж, хянуулан, дарга, тэргүүлэх аудиторовын тушаалаар баталгаажуулж, 2020 оны 06 дүгээр сарын 30-нд аймгийн Засаг даргад хүргүүлэв.

ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 16.2-т “аймаг, нийслэлийн Засаг дарга дараах аж ахуйн үйл ажиллагаа эрхлэхэд тусгай зөвшөөрөл олгоно” гэж заасан.

- эрүүл мэндийн байгууллага мэргэжлийн үйл ажиллагаа явуулах;
- ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэг байгуулах;
- согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх;
- эмчилгээний гоо заслын үйлчилгээ;
- түгээмэл тархацтай ашигт малтмал хайх, ашиглах.

Аймгийн Засаг дарга 2017-2019 онд эмчилгээний гоо заслын үйлчилгээнээс бусад үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгосон байна.

Аймгийн хэмжээнд нийт эрүүл мэндийн байгууллагын тусгай зөвшөөрөл эзэмшигч дараах 101 иргэн ААН байна. Үүнд:

Хүснэгт №1

Д/д	Эрүүл мэндийн тусгай зөвшөөрлийн төрөл	Сумдын нэрс			Нийт дүн
		Сайншанд сум	Замын-Үүд сум	Бусад сумд	
1	Нэгдсэн эмнэлэг	2	1	12	15
2	Хувийн эмнэлэг	19	5	0	24
3	ӨЭМТ	3	1	0	4
4	Эмийн сан	18	10	15	43
5	Ариутгал, халдваргүйжүүлэлт	3	1	0	4
6	ЭХНТ	4	0	0	4
7	Сувилал	2	0	2	4
8	Лаборатори	1	0	0	1
9	Цэргийн эмнэлэг	0	0	2	2
Нийт		52	18	31	101

Аймгийн хэмжээнд 2017 онд 32 цэцэрлэгийн, 2019 онд хувийн өмчийн 1 цэцэрлэгийн тусгай зөвшөөрлийн хугацааг тус тус сунгаж, 2019 онд төрийн өмчийн 2 цэцэрлэгт үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл шинээр олгосон байна. Аймгийн хэмжээнд 405 хүүхдийн хүчин чадал бүхий хувийн өмчийн 4 цэцэрлэг байна.

2018-2019 онд ерөнхий боловсролын 20 сургуульд 13971 сурагч суралцаж байна. Хамран сургалтын хувь суурь боловсрол 90.3 хувь, бага боловсрол 96.9 хувь, сургуулиас гадна байгаа 6-14 насны 38 хүүхэд байна.

Хүснэгт №2

Д/д	Сумын нэр	Сургууль		Цэцэрлэг	
		Сунгасан	Шинээр олгосон	Сунгасан	Шинээр олгосон
1	Айраг	1	-	2	-
2	Алтанширээ	1	-	1	-
3	Даланжаргалан	2	-	2	-
4	Дэлгэрэх	1	-	1	-
5	Иххэт	1	-	1	-
6	Мандах	1	-	1	-
7	Өргөн	1	-	1	-
8	Сайхандулаан	1	-	1	-
9	Улаанбадрах	1	-	1	-
10	Хатанбулаг	1	-	1	1
11	Хөвсгөл	1	-	1	-
12	Эрдэнэ	1	-	1	-
13	Замын-Үүд	2	1	5	2
14	Сайншанд	4	-	12	1
Нийт		19	1	31	4

Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай хуулийн 4.1.1-д “түгээмэл тархацтай ашигт малтмал” гэж зам, барилгын материалын зориулалтаар ашиглах боломжтой, элбэг тархалт бүхий элс, хайрга, тоосгоны шавар, хүрмэн, боржин, дайрганы зориулалттай барилгын чулууны хуримтлалыг гэж тодорхойлсон.

Аймгийн хэмжээнд 2019 оны жилийн эцсийн байдлаар түгээмэл тархацтай ашигт малтмал хайх, ашиглах тусгай зөвшөөрөл олгогдсон хүчин төгөлдөр 22 тусгай зөвшөөрөл байна.

Хүснэгт №3

Д/д	Сумын нэр	ТТАМ хайх тусгай зөвшөөрлийн тоо	ТТАМ ашиглах тусгай зөвшөөрлийн тоо
1	Айраг	5	-
2	Даланжаргалан	5	6
3	Сайхандулаан	1	-
4	Мандах	1	-
5	Өргөн	-	1
6	Сайншанд	-	1
7	Эрдэнэ	1	-
8	Замын-Үүд	-	1
	Дүн	13	9

Үйлдвэр худалдааны сайдын 2008 оны 05 дугаар тушаалаар согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх цэгийн тоог тогтоож өгсөн байна. Нийслэл, аймгийн төвд 2000 хүн ам тутамд 1-ээс хэтрэхгүй байх, сумын төвд согтууруулах ундаа худалдах цэг 1, согтууруулах ундаагаар үйлчлэх цэг 1 байхаар тус тус тогтоосон байна.

Согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрөл эзэмшигч иргэн, ААНБ-ын 2017-2019 оны жилийн эцсийн тоо дараах байдалтай байна.

Хүснэгт №4

Д/д	Сумын нэр	Хүн амын тоо			Батлагдсан норматив			Тусгай зөвшөөрөл олгосон		
		2019	2018	2017	Архи худалдах	Үйлчлэх	Нийт	2019	2018	2017
1	Айраг	3649	3766	3811	1	1	2	8	7	7
2	Алтанширээ	1325	1360	1327	1	1	2	4	3	3
3	Даланжаргалан	2855	2895	2749	1	1	2	13	14	9
4	Дэлгэрэх	1817	1840	1873	1	1	2	5	6	6
5	Иххэт	2092	2112	2108	1	1	2	5	4	3
6	Замын-Үүд	18740	18930	18241	1	1	2	69	66	65
7	Мандах	1556	1596	1587	1	1	2	5	5	3
8	Өргөн	2077	2076	2004	1	1	2	5	5	4
9	Сайншанд	26048	25274	24772	7	6	13	84	81	89
10	Сайхандулаан	1381	1378	1380	1	1	2	3	3	3
11	Улаанбадрах	1482	1482	1470	1	1	2	3	3	3
12	Хатанбулаг	2869	2872	2919	1	1	2	9	9	9
13	Хөвсгөл	1580	1540	1573	1	1	2	3	3	3
14	Эрдэнэ	2355	2439	2378	1	1	2	4	4	3
	Дүн	69826	69560	68192	20	19	39	220	213	210

Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 16.3.4-т сум, дүүргийн Засаг дарга тамхи худалдах үйл ажиллагаанд тусгай зөвшөөрөл олгохоор заасны дагуу Улаанбадрах, Хөвсгөл, Иххэт сумын Засаг даргаас бусад сумын Засаг дарга тамхи худалдах тусгай зөвшөөрөл олгосон байна.

Тусгай зөвшөөрлийн тоог 2019 оны жилийн эцсийн байдлаар харахад: Айраг сум 6, Алтанширээ сум 2, Даланжаргалан сум 5, Дэлгэрэх сум 6, Мандах сум 2, Өргөн сум 5, Сайхандулаан сум 1, Хатанбулаг сум 3, Эрдэнэ сум 5, Замын-Үүд сум 27, Сайншанд суманд 46, сумдад нийт 108 тамхины тусгай зөвшөөрөлтэй иргэн, ААН байна.

БҮЛЭГ 1. Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн шаардлагад нийцүүлж тусгай зөвшөөрөл олгох хэрэгтэй байна.

1.1 Тусгай зөвшөөрөл олгоход баримтлах зарчим, шаардлагыг хангалтгүй хэрэгжүүлсэн байна.

1.1.1. Аж ахуйн тусгай зөвшөөрөл бүхий байгууллагуудын үйл ажиллагааны үр дүнд чиглэсэн бодлого, зорилт дэвшүүлсэн хэдий ч үр дүн нь хангалтгүй байна.

Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн дагуу аймаг, сумын Засаг даргын захирамжаар 5 төрлийн, сумын Засаг даргын захирамжаар тамхи худалдах тусгай зөвшөөрөл олгогддог бөгөөд тэдгээрийн үйл ажиллагааг хөгжүүлэх, дэмжихээр Засаг даргын үйл ажиллагааны 2016-2020 оны хөтөлбөр, аймгийн 2017-2019 оны эдийн засаг нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлд дараах байдлаар бодлого зорилтоо дэвшүүлсэн байна.

- Байгаль орчинд сөрөг нөлөө үзүүлж байгаа компанийн тусгай зөвшөөрлийг цуцлах бодлого баримтална. Уул уурхайн бүтээгдэхүүний тээвэрлэлтийг байгаль орчинд сөрөг нөлөөгүйгээр зохион байгуулахад шаардлагатай арга хэмжээ авч ашиглана.

- Архи согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчилж буй байгууллагуудад хагас жилд нэг удаа мэргэжлийн байгууллагуудын хамтарсан хяналт, шалгалтыг зохион байгуулж, шаардлага хангахгүй байгаа архи худалдаалах болон түүгээр үйлчлэх цэгийн тоог бууруулах, архины хор хөнөөлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй төрийн бус байгууллагын үйл ажиллагааг дэмжиж ажиллах.

- Архи, тамхины хорт зуршлын эсрэг “Эрүүл ирээдүй” дэд хөтөлбөрийг үргэлжлүүлэн хэрэгжүүлэхээр тусгасан ба өсвөр үеийнхэнд тамхины хор хөнөөлийг сурталчлах, сургууль, цэцэрлэг тамхигүй орчин болох хөдөлгөөнийг өрнүүлэх, хүүхэд өсвөр үе, залуучууд, ажил олгогч, иргэдэд мэдээллийн бүхий л сувгаар сурталчлах

- Эрүүл мэнд спортын сайдын 2016 оны А/258 дугаар тушаалаар эрүүл мэндийн байгууллагуудын "Тусгай зөвшөөрөл олгох тэргүүлэх чиглэл"-ийг баталсан бөгөөд эмийн сангийн үйлчилгээнд тусгай зөвшөөрөл олгохдоо хязгаарлалт хийхээр тусгасан байна. Мөн Эрүүл мэндийн сайдын 2018 оны А/421 тоот тушаалаар батлагдсан тэргүүлэх чиглэлийн 2.3.1-д "Эмийн сангийн үйлчилгээ дутагдалтай газар нутгийн хүн амд эм, эмнэлгийн хэрэгсэл, мансууруулах, сэтгэцэд нөлөөлөх эмээр жижиглэнгийн үнээр хангах үйл ажиллагаанд тусгай зөвшөөрөл олгохоор тус тус заасан байна.

Тусгай зөвшөөрөл эзэмшигч аж ахуйн үйл ажиллагааны талаар дэвшүүлсэн дээрх бодлого зорилтуудын биелэлтийг хангуулах чиглэлээр хяналт шалгалт явуулж, цөөлөх бодлого барихаар тусгасан боловч үр дүн гараагүй байна.

- “Дорноговь хариуцлагатай уул уурхай-хамтын ажиллагаа” зөвлөгөөнийг зохион байгуулж нийгмийн болон байгаль орчны хариуцлагыг нэмэгдүүлэх, сум орон нутгийн жижиг дунд үйлдвэрлэгчдийг дэмжих, татварын өр төлбөргүй ажиллах асуудлыг хэлэлцсэн байна.

ТТАМ-ын хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч ААН нь аймаг, сумын ЗДТГ-т тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хариуцлагатайгаар хугацаанд нь ирүүлээгүй, шаардаж аваагүй, сөрөг нөлөөллийг бууруулах ямар ажил зохион явуулсан нь тодорхой бус, олборлолтод өртөж, эвдрэлд орсон газар нутгийг нөхөн сэргээсэн тухай нэгтгэсэн мэдээ судалгаа байхгүй байна.

- Архи согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчилж буй байгууллагуудад 2017 онд нэг удаа аймгийн Засаг даргын нэгдсэн удирдамжаар мэргэжлийн байгууллагуудын хамтарсан өргөн хүрээтэй хяналт, шалгалтыг зохион байгуулсан бөгөөд сумдад баяр ёслолын үеэр цагдаа, татвар, сумын ХХАА-н мэргэжилтнүүд хамтран худалдаа, үйлчилгээний газарт хяналт шалгалтыг тогтмол хэрэгжүүлсэн байна. Харин архи худалдаалах цэгийн тоог бууруулах гэсэн зорилт тавьсан хэдий ч тусгай зөвшөөрөлтэй цэгийн тоо жил бүр өссөн үзүүлэлттэй байна. Тодруулбал 2017 оны эцэст 210, 2018 оны эцэст 213, 2019 оны эцэст 220 байна.

- ЭМСС-ын сайдын тэргүүлэх чиглэлд эмийн сангийн үйлчилгээнд хязгаарлалт хийхээр тусгасан байтал 2017-2019 онд шинээр 9 эмийн санд үйл ажиллагаа явуулах тусгай зөвшөөрөл олгосон байна.

1.1.2. Аймгийн ИТХ-аас хуулийн хязгаарт багтаан тэмдэгтийн хураамжийг тогтоосон хэдий ч хэрэгжилтийг хянах үйл явц хангалтгүйгээс тэмдэгтийн хураамж дутуу төвлөрүүлсэн байна.

Түгээмэл тархацтай ашигт малтмал хайх тусгай зөвшөөрөл шинээр авахаар хүсэлт гаргахад Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуулийн 25.1.5-д зааснаар үйлчилгээний хөлс болох 250.0 мянган төгрөг төлөхөөр заасны дагуу тусгай зөвшөөрөл хүссэн ААН-үүд үйлчилгээний хөлсийг бүрэн төлсөн байна.

Мөн ашиглалтын тусгай зөвшөөрөл шинээр авахаар гаргасан өргөдлийг хянан үзэхэд Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуульд 1.0 сая төгрөгийн үйлчилгээний хөлс авна гэж заасан бөгөөд 2017-2019 онд ашиглалтын тусгай зөвшөөрөл олгосон 4 компаниас тус бүр 1.0 сая төгрөгийн үйлчилгээний төлбөрийг авсан байна.

Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуулийн 35.6-д “түгээмэл тархацтай ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрлийн төлбөрийг хайгуулын талбайн гектар тутамд 100-1000 төгрөг төлөхөөр, ашиглалтын тусгай зөвшөөрлийн төлбөрийг ашиглалтын талбайн гектар тутамд 5000-20000 төгрөг төлөхөөр хуульчилсан байна.

ТТАМ хайх тусгай зөвшөөрөл бүхий компаниуд жил бүр хуульд заасан хэмжээгээр тусгай зөвшөөрлийн төлбөрийг төлсөн байна. Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуульд заасан тусгай зөвшөөрлийн төлбөрийн хэмжээ бага байгаа асуудлыг холбогдох газарт уламжилж, төлбөрийн хэмжээг нэмэгдүүлснээр орон нутгийн орлого нэмэгдэх боломжтой болох юм. Тодруулбал: 26.0 гектар талбай бүхий хайгуулын тусгай зөвшөөрөлд эхний жил 2600 төгрөг, 361.5 гектар талбай бүхий тусгай зөвшөөрлийн төлбөр 36150 төгрөг болж байна.

Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай хууль батлагдахаас өмнө Ашигт малтмал, газрын тосны газраас ашиглалтын тусгай зөвшөөрөл авсан дараах компани байгаа бөгөөд эдгээр компаниуд орон нутгийн төсвийн дансанд тусгай зөвшөөрлийн төлбөр төлөөгүй ба анх зөвшөөрөл авахдаа төлбөр төлсөн дансандаа төлбөрөө /нийт 5220.4 мянган төгрөг/ төлдөг байна.

Хүснэгт №5

Д/д	Сумын нэр	Компанийн нэр	Ашигт малтмал	ТТАМ ашиглах тусгай зөвшөөрөл олгосон огноо	Талбайн хэмжээ /га/	1 жилд төлөх төлбөрийн хэмжээ /мян. төг/
1.	Даланжаргалан	УБТЗ-ын Чулуун овоо	Барилгын материал	1988.04.16	22.62	180.9
2.	Сайншанд	Дорнын цеолит ХХК	Боржин	2005.10.06	64.84	972.6
3	Даланжаргалан	МАК Цемент ХХК	Барилгын материал, шавар	2010.12.08	87.57	1313.6
4.	Даланжаргалан	Мэжиктийм ХХК	Барилгын материал	2014.04.16	183.55	2753.3
		Дүн				5220.4

Аймгийн Засаг даргын захирамжаар ашиглалтын тусгай зөвшөөрөл авсан ХХК ашиглалтын тусгай зөвшөөрлийн төлбөрийг 2017-2019 онд бүрэн буюу нийт 44598.9 мянган төгрөг төлсөн байна. Үүнд:

Хүснэгт №6

Д/д	Сумын нэр	Компанийн нэр	Газрын нэр	ТТАМ хайх тусгай зөвшөөрлийн дугаар	Талбайн хэмжээ /га/	1 жилд төлвөл зохих төлбөр /мян.төг/	Төлсөн төлбөрийн дүн мян.төг /2017-2019 он/
1.	Замын-үүд	МЦЦТ ХХК	Хайрга	2016.08.09	26	208.0	624.0
2.	Даланжаргалан	МАК Цемент ХХК	шавар	2017.03.28	373.22	7464.4	22393.2
3.	Өргөн	Бишрэлт түшлэг ХХК	хайрга	2017.05.22	84.50	1267.5	3802.5
4.	Даланжаргалан	Өндөр чулуут ХХК	Хайрга	2018.11.17	396.98	7939.6	15879.2
5.	Даланжаргалан	Сүмбэр билэг ХХК	хайрга	2019.11.21	180.0	1900.0	1900.0
	Дүн						44598.9

Аймгийн Засаг даргаас тусгай зөвшөөрөл олгоход хураах тэмдэгтийн хураамжийн хэмжээг аймгийн ИТХ тогтоох байтал аймгийн ИТХТ-ийн 2011 оны 09 сарын 14-ний өдрийн 51 дүгээр тогтоолоор тогтоосон байна. Тогтоолд хуульд нийцэхгүй зарим зүйл заалт байна. Үүнд:

1. Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуулийн 35.1.1-35.1.3-т заасан хураамж нь аймгийн ИТХ-ын бүрэн эрхэд хамааралгүй байна.
2. Тамхины хяналтын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.7.15-д “баар, цэнгээний газарт тамхи худалдах”-ыг хориглосон байдаг. /Энэ заалтыг 2012 оны 10 дугаар сарын 24-ний өдрийн хуулиар нэмсэн/

ИТХТ-ийн тогтоолоор баталсан Улсын тэмдэгтийн хураамжийн хувь хэмжээг тусгай зөвшөөрөл тус бүрээр харуулбал:

1. Согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрөл олгоход хураах улсын тэмдэгтийн хураамжийн хэмжээ: Согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрөл олгоход хураах хураамжийн хэмжээг аймгийн ИТХ-аас Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуулиар тогтоосон хураамжийн дээд хязгаараар, аймгийн төвийн сум, бусад суманд ялгаатай тогтоосон байна. Үүнээс аймгийн төвийн сумын тарифыг харуулбал:

Хүснэгт №7

Д/д	Төрөл	Худалдах тусгай зөвшөөрөл /мян. төг/	Үйлчлэх тусгай зөвшөөрөл /мян. төг/
1	Спиртийн өндөр агууламжтай согтууруулах ундаа	600.0	800.0
2	Спиртийн өндөр агууламжтай согтууруулах ундаа худалдах тусгай зөвшөөрлийн хугацааг сунгах	200.0	400.0
3	Спиртийн сул агууламжтай согтууруулах ундаа	200.0	400.0
4	Спиртийн сул агууламжтай согтууруулах ундаа худалдах тусгай зөвшөөрлийн хугацааг сунгах	70.0	200.0

Аймгийн ЗДТГ-ын ХОХБТХ тусгай зөвшөөрөл олгоход ААНБ улсын тэмдэгтийн хураамжийг тогтоосон тарифын дагуу төлсөн эсэхийг хянаж бүртгэсэн хэдий ч төлбөрөө бүрэн төлөөгүй байхад тусгай зөвшөөрөл олгосон, сунгасан байна.

2. Тамхи худалдах тусгай зөвшөөрлийн улсын тэмдэгтийн хураамж: Баар, бөөний худалдааны төв 200.0 мянган төгрөг, жижиг дэлгүүр, сумын төвийн 8 нэрийн дэлгүүр 150.0 мянган төгрөг, ТҮЦ, мухлаг 100.0 мянган төгрөг төлөхөөр тогтоосон байна.

Аймгийн хэмжээнд тамхины тусгай зөвшөөрөлтэй иргэн, ААНБ 2018 онд 4,800.0 мянган төгрөг, 2019 онд 8,900.0 мянган төгрөгийн тэмдэгтийн хураамжийг бүрэн төлсөн байна.

Харин Замын-Үүд сум аймгийн ИТХ-аас тогтоосон тэмдэгтийн хураамжийг баримтлалгүй иргэнээс 100.0 мянган төгрөг, аж ахуйн нэгжээс 250.0 мянган төгрөгөөр тэмдэгтийн хураамжийг авч байна.

Сангийн сайдын 2015 оны 7 дугаар тушаалаар баталсан “Орлогын эдийн засгийн ангилал”-д бусад татвар, төлбөр хураамжийн орлогын төрөлд улсын тэмдэгтийн хураамжийг ангилан бүртгэхээр заасан байхад Замын-Үүд суманд 2018 онд 1050.0 мянган төгрөг, 2019 онд 3900.0 мянган төгрөг, нийт 4950.0 мянган төгрөгийн тамхины тусгай зөвшөөрлийн тэмдэгтийн хураамжийг ОНХО-ын дансанд төвлөрүүлсэн байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 22.6.3-т “төсвийн төлөвлөлт, бүртгэл, тайлагналтыг төсвийн ангиллын төрөл тус бүрээр, тэдгээрийн дэлгэрэнгүй ангиллын дагуу бэлтгэх” гэсэнтэй нийцэхгүй байна. Иймд улсын тэмдэгтийн хураамжийн дансанд оруулах албан шаардлага бичлээ.

3. Эрүүл мэндийн байгууллагын тусгай зөвшөөрлийн улсын тэмдэгтийн хураамж: Эрүүл мэндийн байгууллага байгуулах, эмчилгээний гоо заслын үйлчилгээ үзүүлэх тусгай зөвшөөрөл олгоход хураах тэмдэгтийн хураамжийг 200 000-400 000 төгрөг байхаар тогтоосон нь Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуулийн 6.2.-т “.....27.1.1, 27.1.4-27.1.6 дахь заалт, 27.2-27.4..... дэх зүйлд заасан тэмдэгтийн хураамжийн хэмжээг энэ хуульд заасан хязгаарт багтаан Засгийн газар тогтооно” гэж заасантай нийцэхгүй байна.

Эрүүл мэнд спортын сайдын тушаалаар тусгай зөвшөөрлийн бүрдүүлэх баримт бичигт тавигдах шаардлага, тэмдэгтийн хураамжийн хэмжээ, олгох журам, баримтлах тэргүүлэх чиглэлийг тус тус баталж мөрдөж байна.

ЭМС-ын баталсан тэмдэгтийн хураамжийн хэмжээг баримтлаагүй, төлсөн эсэхийг хянаагүйгээс 2018, 2019 онуудад 5 үүдэн эмнэлэг 1.4 сая төгрөгийн хураамж дутуу төлсөн, 7 эмийн сан, эмнэлэг 770.0 мянган төгрөгийн хураамж төлөөгүй байв.

Аудитын явцад нийт 2,170.0 мянган төгрөгийн улсын тэмдэгтийн хураамжийг холбогдох аж ахуйн нэгжүүдээр нөхөн төлүүллээ. Аймгийн ИТХТ-ийн 2011 оны 51 тогтоолыг хүчингүй болгож аймгийн ИТХ-аар улсын тэмдэгтийн хураамжийн хэмжээг тогтоох хэрэгтэй байна.

1.1.3 Нийгэмд учрах эрсдэл, бодит хэрэгцээ зэргийг судлаагүй, зөвхөн хууль эрхзүйн шаардлага хангасан тохиолдолд тусгай зөвшөөрөл олгосон байна.

Аймгийн ИТХ-аас 2018 онд "Архидан согтуурахтай тэмцэх, түүний хор хөнөөлөөс урьдчилан сэргийлэх" аймгийн дэд хөтөлбөрийг баталж 5 зорилт дэвшүүлсэн байна. Зорилт 5-д Архидан согтуурснаас үүдэлтэй гэмт хэрэг, зөрчлийн тоог бууруулах, архи, согтууруулах ундаагаар үйлчлэх тусгай зөвшөөрөлтэй аж ахуйн нэгжийн үйл ажиллагаанд тавих хяналтыг сайжруулж, нийгмийн хариуцлагыг нэмэгдүүлэхээр тусгасан байна.

Архи, согтууруулах ундаа худалдах, үйлчлэх тусгай зөвшөөрлийг олгохдоо хэрэгцээ шаардлага, эрүүл мэнд, хэрэглэгчийн аюулгүй байдал зэргийг судлаагүй шинээр олгосон, тусгай зөвшөөрөл эзэмших хугацаанд тавигдах шаардлага болон нийгмийн хариуцлагаа хэрхэн биелүүлсэн, зөрчил гаргасан эсэх, түүнийг хэрхэн биелүүлсэн эсэхийг харгалзан үзэлгүйгээр тусгай зөвшөөрлийг сунгасан байна.

Аймгийн ЗДТГ-нь Засгийн газрын болон орон нутгийн бодлого шийдвэр, хөтөлбөр арга хэмжээний зорилго зорилтууд хэрхэн хангагдаж байгаад хяналт тавиагүй холбогдох байгууллагуудтай харилцан уялдаатай ажиллаагүй байна. Аймгийн хэмжээнд гарсан хэрэг зөрчлийг авч үзэхэд 2019 оны жилийн эцэст согтуугаар үйлдсэн гэмт хэргийн тоо 179 байсан ба энэ нь өмнөх оноос 109-өөр нэмэгдсэн байна.

ТХТ хуулийн 7 дугаар зүйлийн 7.3-т зааснаар тамхи худалдах тусгай зөвшөөрлийг сумын Засаг дарга олгож байна. Сумын Засаг даргын захирамжаар 2017-2019 онуудад нийт 108 тамхи худалдах тусгай зөвшөөрлийг олгосон байна.

Тамхины тусгай зөвшөөрөл эзэмшигч иргэн, ААНБ-ын тоо 2019 онд өмнөх оноос 20 буюу 62%-аар өссөн байна.

График №1




Харин Иххэт, Улаанбадрах, Хөвсгөл сумдад тамхи худалдах тусгай зөвшөөрөлтэй иргэн, аж ахуйн нэгж байхгүй байна. Тус сумдын дэлгүүрүүд нь ерөнхий боловсролын сургуулийн хичээлийн болон дотуур байраас 500 метрийн дотор зайд байрладаг гэсэн тайлбарыг өгсөн ба сумын иргэдээс дэлгүүрт тамхи худалддаг эсэхийг асуухад бүх дэлгүүр тамхи худалддаг гэж хариулж байв. Иймд хуулийн хүрээнд шаардлага хангаж буй иргэн, аж ахуй нэгжид тусгай зөвшөөрлийг олгох тухай албан шаардлагыг сумдын Засаг дарга нарт хүргүүлэв.

Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулиар аймаг, нийслэлийн Засаг дарга ерөнхий боловсролын сургууль цэцэрлэг байгуулах тусгай зөвшөөрлийг олгохоор хуульчилсан байна.

Аймгийн Засаг дарга 2017 онд 32 цэцэрлэгийн, 2019 онд хувийн өмчийн 1 цэцэрлэгийн тусгай зөвшөөрлийн хугацааг тус тус сунгаж, 2019 онд төрийн өмчийн 2 цэцэрлэгт үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл шинээр олгосон байна. Аймгийн хэмжээнд 405 хүүхдийн хүчин чадал бүхий хувийн өмчийн 4 цэцэрлэг байна.

График 2



СӨБ-д 2017-2019 онд хамрагдаагүй цэцэрлэгийн насны 600 гаруй хүүхэд байна.

2018-2019 онд ЕБ-ын 22 сургуульд 13971 сурагч суралцсан байна. Хамран сургалтын хувь суурь боловсрол 90.3 хувь, бага боловсрол 96.9 хувь байна. Цэцэрлэг, сургуулийн хэрэгцээ шаардлагад нийцүүлж стандартын шаардлага хангасан төрийн болон хувийн өмчийн сургууль, цэцэрлэг байгуулах саналыг дэмжих нь зүйтэй байна.

ЭМСС-ын 298 тоот тушаалаар баталсан Комиссын ажиллах журмын 1.3-т “Хүн амын эрүүл мэндийн бодит хэрэгцээ шаардлага”-ыг баримтална гэж заасан байна. Мөн журамд Комиссын хурлаар хэлэлцэх үндсэн асуудалд “Тусгай зөвшөөрөл хүсэгчийн шинээр байгуулах эрүүл мэнд, эм хангамжийн байгууллагын төсөлд Эрүүл мэнд, спортын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас баримталж буй тэргүүлэх чиглэл, эрүүл мэндийн тусламж үйлчилгээний бодит хэрэгцээ шаардлагад нийцэж байгаа эсэхийг тодорхойлж албан ёсны хариуг өгөх, шинжээч томилох эсэхийг шийдэх” гэж тус тус заасан байна.

Тусгай зөвшөөрлийн комиссын ажиллах журмын дагуу хүн амын эрүүл мэндийн хэрэгцээ, шаардлагын судалгааг гаргаагүй, аймгийн хэмжээнд тэргүүлэх чиглэлийг тодорхойлсон саналаа ЭМЯ-д хүргүүлээгүй байна.

1.1.4 Тусгай зөвшөөрөл олгох нормативт хэмжээг баталсан эрх зүйн актад нийцүүлж үйл ажиллагаа явуулаагүй байна.

Үйлдвэр худалдааны сайдын 2008 оны 05 дугаар тушаалаар согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх цэгийн тоог тогтоож өгсөн байна. Үүгээр нийслэл, аймгийн төвд 2000 хүн ам тутамд 1-ээс хэтрэхгүй байх, сумын төвд согтууруулах ундаа худалдах цэг 1, согтууруулах ундаагаар үйлчлэх цэг 1 байхаар тус тус тогтоосон байна. Аймгийн хэмжээнд 2019 оны жилийн эцсийн хүн амын тоо 69826 байсан бөгөөд архины зөвшөөрөлтэй цэгийн тоо нормативаар 39 байх байтал 220 цэгт тусгай зөвшөөрөл олгосон байна.

Үйлдвэр худалдааны сайдын тушаалаар баталсан "Норматив тогтоох тухай" тушаал нь захиргааны хэм хэмжээ тогтоосон шийдвэрийн улсын нэгдсэн бүртгэлийн санд бүртгэгдээгүйгээс захиргааны хэм хэмжээний акт эрх зүйн үйлчлэл үзүүлэхгүй, биелүүлээгүй иргэн, хуулийн этгээдэд үүрэг хариуцлага хүлээлгэх чадамжгүй байна. Мөн согтууруулах ундаа худалдах, үйлчлэх цэгийн тоо хүртээмжтэй бус байдлаас шалтгаалж стандарт бус согтууруулах ундаа худалдах,

зөвшөөрөлгүйгээр гар дээрээс худалдах, зөвшөөрөлгүй цэгт согтууруулах ундаа хэрэглэж, хэрэг зөрчлийн тоо нэмэгдэхээс сэргийлж нормативыг харгалзан үзээгүй байна.

Эрүүл мэнд спортын сайдын 2016 оны А/258 дугаар тушаалаар баталсан 2016-2017 онд Эрүүл мэндийн чиглэлээр мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгоход баримтлах тэргүүлэх чиглэлийн 3.1-т “Эмийн сангийн үйлчилгээнд хязгаарлалт хийхээр, мөн эмийн сангийн үйлчилгээ дутагдалтай газар нутгийн хүн амд эм, эмнэлгийн хэрэгсэл, мансууруулах, сэтгэцэд нөлөөлөх эмээр жижиглэнгийн үнээр хангах үйл ажиллагааг дэмжиж олгох” гэж тусгасан байна.

Эрүүл мэндийн тусгай зөвшөөрөл олгоход баримтлах тэргүүлэх чиглэлд зарим төрлийн эрүүл мэндийн үйл ажиллагаа эрхлэхэд хязгаарлалт хийхээр зохицуулсан боловч түүнийг баримтлаагүй, нэмж олгосон байна. Айраг, Даланжаргалан сумд нь 3000-аас доош хүн амтай боловч тус бүр 2 эмийн сан байрлаж, үйл ажиллагаа явуулж байна.

1.2 Тусгай зөвшөөрөл бүхий байгууллагууд хууль тогтоомж, стандартын шаардлагыг бүрэн хэрэгжүүлж ажиллаагүй, стандартад нийцүүлж тохирлын гэрчилгээ олгоогүй байна.

1.2.1 Хариуцсан албан тушаалтан болон ААНБ-ын хариуцлагагүй байдлаас шалтгаалж тусгай зөвшөөрөл олгохтой холбоотой хууль эрхзүйн актын хэрэгжилт хангалтгүй байна.

ТТАМ-ын тухай хуульд нэг тусгай зөвшөөрлөөр олгох түгээмэл тархацтай ашигт малтмалын хайгуулын талбайн хэмжээ 25 гектараас багагүй, 400 гектараас ихгүй байна, ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрөлтэй талбайд зөвхөн тухайн зөвшөөрөл эзэмшигч нь ашиглалтын тусгай зөвшөөрөл хүсэж өргөдөл гаргах эрхтэй гэсэн шаардлагыг хангасан байна. Компаниуд ТТАМ-ын хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрөл авахдаа хуульд заасны дагуу бичиг баримтуудыг бүрдүүлсэн байна.

Аж ахуйн тусгай зөвшөөрлийн тухай хууль болон аймгийн ИТХ-ын тогтоолоор баталсан Согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрөл олгох, хяналт тавих журмын дагуу тусгай зөвшөөрөл хүсэгч ААНБ-аас шаардлагатай баримт бүрдүүлсний үндсэн дээр тусгай зөвшөөрөл олгох хэдий ч баримтын бүрдэл хангагдаагүй байна. Тодруулбал: Захирлын иргэний үнэмлэхийн хуулбар, улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар, татварын хэлтсийн тодорхойлолт, хүсэлт гаргасан өдөр хэвлэсэн Е баримтын хуулбар, барилгын схем зураг, худалдаа үйлчилгээ явуулах танхимын зохион байгуулалтын зураг, улсын бүртгэлийн хураамж төлсөн баримт, цагдаагийн байгууллагаас ирүүлэх тодорхойлолт, сумын засаг даргын санал зэрэг нь тусгай зөвшөөрөл шинээр авах, сунгуулах тухайн ААНБ-ын хувьд 100 хувь бүрэн байхгүй байна.

Сумд тамхины тусгай зөвшөөрөл олгохдоо хариуцсан мэргэжилтэн нь шаардлагатай баримт бичгийн бүрдлийг хянан үзэж Засаг даргын захирамж гаргадаг бол Сайншанд сум нь Засаг даргын Зөвлөлийн хурлаараа хэлэлцүүлэн шийдвэрлэдэг байна.

Галын аюулгүй байдлын дүгнэлтийн хугацаа дууссан байхад 2019 онд Айраг сум 1, Сайншанд сум 2, Замын-Үүд сум 1 тусгай зөвшөөрөл олгосон байна. Мөн Замын-Үүд сум 2018 онд олгосон тамхины тусгай зөвшөөрлийн баримтын бүрдэлд галын аюулгүй байдлын дүгнэлтийг огт бүрдүүлээгүй байна. 2019 онд Сайншанд суманд тусгай зөвшөөрөл хүссэн 1 иргэний цэгийн байршил сургуулийн 500 метрийн дотор зайд байсан учир зөвлөлийн хурлаар дэмжигдээгүй байна.

ААҮАТЗТ хуулийн 16 дугаар зүйлийн 16.2.4-д ЕБС, цэцэрлэг байгуулах үйл ажиллагаа эрхлэхэд аймгийн Засаг дарга тусгай зөвшөөрөл олгоно, Боловсролын сургалтын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг Боловсролын тухай хуулийн 22.2¹-д заасан журмаар олгоно гэж заасан байдаг.

Цэцэрлэгүүд Боловсролын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д заасан боловсролын сургалтын байгууллагыг үүсгэн байгуулагч нь тусгай зөвшөөрөл авахдаа боловсролын сургалтын байгууллага байгуулах тухай эрх бүхий байгууллагын шийдвэр, өргөдөл, дүрэм, үүсгэн байгуулах тухай гэрээний аль нэг, боловсролын сургалтын байгууллага байгуулах үндэслэл, тооцоо бүхий танилцуулга, сургалтын төлөвлөгөө, багшлах боловсон хүчний хангамж, бүрэлдэхүүн, боловсролын түвшин, зэрэг, цолны судалгаа, сургалт явуулах барилга байгууламж, техник хэрэгсэл, ном, сурах бичиг зэрэг сургалтын хэрэглэгдэхүүний баталгаа, санхүүгийн эх үүсвэр, хүчин чадал, түүний баталгаа, үүсгэн байгуулагчаас сургалтын байгууллагын мэдэлд шилжүүлэх хөрөнгө /биет болон мөнгөн/-ийн жагсаалт, хэмжээ, баталгаа, байгууллагын эзэмшил газрын зөвшөөрөл зэрэг баримтын бүрдлийг хангаж тусгай зөвшөөрөл авсан байна.

Эрүүл мэндийн үйл ажиллагааны тусгай зөвшөөрөл олгохдоо ААҮАТЗТ хуульд заасан бичиг баримтын бүрдлийг хангуулаагүй байна. Үүнд: иргэний үнэмлэхийн хуулбар, улсын тэмдэгтийн хураамж төлсөн баримт, үйл ажиллагаа явуулах барилга байгууламжийн гаднах орчны аюулгүй байдлыг хангах зорилгоор дүрс бичлэгийн техник, хэрэгсэл суурилуулж, энэ талаар цагдаагийн байгууллагын санал зэрэг баримт бичгүүдийг бүрэн ирүүлээгүй байна.

Аймгийн ЗД-ын 2016 оны А/574 дугаар захирамж, 2017 оны А/324 тоот захирамжаар сонгон шалгаруулалт зарлаагүй, шалгуур үзүүлэлтийг хангаагүй шинжээчийг томилсон байна.

Шинжээчийг 2 жил хүртэлх хугацаагаар томилох ёстой байсан ч 9 шинжээчийг хугацаагүйгээр томилсон байна. 2017-2019 онд шинээр олгосон болон сунгалт хийсэн нийт 55 ААН-д тусгай зөвшөөрөл олгосноос бүрдүүлэх бичиг баримтын шаардлага бүрэн хангасан газар байхгүй байна. Эрүүл мэндийн үйл ажиллагааны тусгай зөвшөөрөл олгохдоо тусгай зөвшөөрлийн комисс болон төсөл ирүүлсэн иргэн, ААН-ээс ЭМТ хуульд заасан 8 төрлийн бичиг баримтын бүрдлийг голчлон анхаардаг ба улсын тэмдэгтийн хураамжийг тусгай зөвшөөрөл олгохоос өмнө хурааж аваагүй, суманд салбар нээх төсөл ирүүлж байгаа ААН цахимаар хадгалсан төслийн нэрийг шууд өөрчилж тусгай зөвшөөрлийн комиссоод ирүүлсэн

¹ Тусгай зөвшөөрөл олгох эрх бүхий байгууллага баримт бичгийг үүсгэн байгуулагчаас хүлээн авснаас хойш ажлын 21 өдрийн дотор боловсролын сургалтын байгууллага байгуулах урьдчилсан зөвшөөрөл олгох эсэхийг шийдвэрлэх, шинжээчийн хэсэг томилогдсоноосоо хойш 30 хоногт багтаан баримт бичигт магадлан шинжилгээ хийж, газар дээр нь танилцан дүгнэлт гаргах, аймгийн Засаг дарга шинжээчийн хэсгийн дүгнэлтийг үндэслэн тусгай зөвшөөрөл олгох эсэх талаар шийдвэр гаргаж, үүсгэн байгуулагчид мэдэгдэх, тусгай зөвшөөрлийг олгох.

байна. Жишээ нь: Монсей Дижиг ХХК нь Замын-Үүд суманд салбар байгуулах төсөл хүргүүлэхдээ Сайншанд суманд байгуулсан эмнэлгийн төслийг бүхэлд нь хуулбарлан худал баримт бичиг бүрдүүлсэн байхад түүнийг журамд заасны дагуу түдгэлзүүлээгүй, шинжээч томилж тусгай зөвшөөрөл олгосон байна.

1.2.2 Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрөл бүхий байгууллагуудад мэргэжлийн боловсон хүчин дутмаг, санхүүгийн чадавх сул, материаллаг байдал хангалттай бүрдээгүй байна.

Аймгийн ИТХ-ын 2017 оны 06/05 дугаар тогтоолоор баталсан Согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрөл олгох, хяналт тавих журмын 4-т "Тусгай зөвшөөрөлтэй цэг нь хууль тогтоомж, стандартын дагуу баригдсан барилга байгууламж, хөдөлмөрийн аюулгүй байдал, технологи, ариун цэвэр, эрүүл ахуйн үндсэн шаардлага хангасан байранд үйл ажиллагаа явуулах, ажлын байр бүтээгдэхүүн үйлчилгээ нь Тохирлын гэрчилгээгээр баталгаажсан байх, татварын хэлтэст татвар төлөгчөөр бүртгүүлж ногдуулсан татварыг хугацаанд нь төлж, НӨАТ-ын баримт олгодог байх, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд үйлчлэх зориулалтын тохижилт хийгдсэн байх" гэж ААНБ-д тавигдах шаардлагыг тодорхойлсон.

Тусгай зөвшөөрөл бүхий бүх цэгт тохирлын гэрчилгээ авсан, ажлын байрны галын аюулгүй байдлын дүгнэлт гаргуулсан, татварын хэлтэст татвар төлөгчөөр бүртгүүлсэн баримт НӨАТ-ын Е баримтыг олгосон байна.

Харин төрийн байгууллагуудын хооронд болон хувийн хэвшлийн газруудын ажлын уялдаа холбоогүй байдлаас шалтгаалж ААНБ нь худалдаа үйлчилгээний барилга барихдаа мэргэжлийн байгууллагуудаас зөвлөгөө авдаггүй, нийтийн эрх ашгийг боддоггүй, хариуцлагаа ухамсарладаггүй байна. СХЗХ нь стандартын шаардлагын тодорхой хувийг биелүүлээгүй байхад тохирлын гэрчилгээ олгосон байна.

Аудитаар зарим ААНБ-д Тохирлын гэрчилгээ олгосон байдлыг ажиглахад стандартын шаардлагын 60-аас дээш хувийг хангасан үед тохирлын гэрчилгээ олгосон ба баталгаажуулалтын салбар зөвлөлийн хурлын тэмдэглэл болон үнэлгээний хуудсыг бүрэн хөтлөөгүй, тохирлын гэрчилгээ хэрэглэх гэрээг гарын үсгээр бүрэн баталгаажуулаагүй байв.

Стандарт хэмжил зүйн хэлтэс худалдаа, үйлчилгээний газруудад 2017-2019 оны 10 сарын 1 хүртэл "Худалдааны газар, түүний үйлчилгээ Техникийн шаардлага MNS5021:2007" стандарт, 2019 оны 10 сараас "Жижиглэн худалдааны газар, түүний үйлчилгээ ерөнхий шаардлага MNS5021-1:2019" стандартыг баримтлан Тохирлын гэрчилгээг 1-3 жилийн хугацаатай олгосон байна. Стандартын ерөнхий шаардлагын үзүүлэлтүүдийг хангаагүй байхад тохирлын гэрчилгээ олгосон байна.

Тухайлбал:

"Барилга байгууламж, гадаад дотоод орчинд тавигдах шаардлага"-д заасан дараах шаардлага:

-Мэргэжлийн байгууллагын зураг төслийн дагуу худалдаа үйлчилгээний зориулалтаар баригдсан байна.

-Барилга байгууламж нь ХБИ-ий хэрэгцээг хангахаар төлөвлөгдсөн, тэргэнцрийн зориулалтын зам, тохижилттой байна.

-Нийт талбайн 30-аас доошгүй талбайд ногоон байгууламж авто машины зогсоолыг төлөвлөсөн байна.

-Хог хаягдлыг ангилан ялгаж хаях хогийн савыг орох хаалганы гадна дотор талд байрлуулсан байна.

-Бараа хүлээн авах буулгах тавцан, тэмдэглэгээ бүхий цардсан зам талбайтай байна.

"Худалдааны ажилтны ур чадвар, мэдлэг боловсролд тавих шаардлага"-д заасан дараах шаардлага:

-Худалдааны зөвлөх, худалдагч, борлуулагч нь мэргэжлийн үнэмлэхтэй байх.

-Гэрээт ажилтан буюу цагийн ажилтан нь мэргэшүүлэх түр сургалтад хамрагдсан байх, худалдаа үйлчилгээтэй холбоотой хууль тогтоомж, дүрэм журам, стандартыг судалж мөрдөж ажиллах.

БСШУСС-ын 2019 оны А/118 дугаар тушаалаар баталсан Цэцэрлэгийн үлгэрчилсэн дүрмийн 2.6-д "цэцэрлэгийн бага бүлгийг дунджаар 20, дунд, ахлах, бэлтгэл бүлгийг дунджаар 25, холимог бүлгийг дунджаар 20 хүүхэдтэй, яслийн бүлэгтэй бол 15 хүүхэдтэйгээр зохион байгуулна" гэж тусгасан. Гэтэл хүн амын нягтрал, шилжилт хөдөлгөөнөөс хамааран Замын-Үүд, Сайншанд сумдад цэцэрлэгийн барилгууд шинээр баригдаж, СӨБ олгох үйл ажиллагаагаа явуулж байгаа ч цэцэрлэгт явах хүүхдийн тоо жилээс жилд нэмэгдэж, нэг багшид дунджаар 35-40 хүүхэд оногдож байна.

Нэг багшид ногдох хүүхдийн тоо 15-20 хүүхдээр илүү байгаа нь хүүхэд бүрийг ажиглах, хөгжүүлэх, сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэх, өдрийн дэглэмийг мөрдөх, хүүхдийн хувийн хэрэг хөтлөх, мэдээ тайлан гаргах зэрэг ажлыг гүйцэтгэхэд хүндрэлтэй болгож, багш нарын ажлын ачааллыг нэмэгдүүлдэг байна. Мөн ээлжийн багш ажиллуулах орон тоо, төсөв батлагддаггүйгээс ажлын цагийг зохистой ашиглах, хүүхдийн насан туршийн боловсролын суурь чадвар эзэмшүүлэх зорилгын хэрэгжилтэд сөргөөр нөлөөлж байна.

Хүүхдийн тоо их байх тусам тухайн цэцэрлэгт зардлын төсөв бодит гүйцэтгэлээс илүү тооцогдох, хүүхдийн тоо бага байх тусам холбогдох зардалд төсөв хүрэлцэхгүй байдалд хүрсэн байна. Үүнээс шалтгаалж төсвийн хуваарилалтыг оновчгүй хийх, стандартын дагуу шаардлагатай нормын хувцас, зөөлөн эдлэл, ном, гарын авлага, тоглоом, сургалтын хэрэглэгдэхүүнийг авах зардлын төсөв хүрэлцэхгүй байна.

Аймгийн хэмжээнд зөвхөн Замын-Үүд суманд хувийн өмчийн 4 цэцэрлэг СӨБ олгох үйл ажиллагааг явуулдаг бөгөөд аудитын явцад үйл ажиллагаатай танилцав. СӨБТ хуулийн 8 дугаар зүйлд заасан цэцэрлэгт эрхлэгч, арга зүйч, багш, туслах багш, эмч, тогооч болон үйлчилгээний бусад ажилтан ажиллана, цэцэрлэгийн нэг бүлэгт багш, туслах багш ажиллана гэсэн заалттай нийцэж байна.

БСШУС-ын 2010 оны 353 дугаар тушаалаар баталсан "Сургуулийн өмнөх болон бага, дунд боловсролын сургалт эрхлэх тусгай зөвшөөрөл авахад бүрдүүлэх баримт бичигт тавигдах шаардлага"-ын 2 дугаар зүйлийн 2.10-д сургалтын байгууллага нь нийт багш нарын 90-ээс доошгүй хувийг мэргэжлийн үндсэн багш байхаар бүрдүүлсэн байна, бага насны хүүхдийг хөгжүүлж, хүмүүжүүлэх чиглэлээр 3 кредит цагаас доошгүй хугацааны сургалтад хамрагдсан туслах багш ажиллах ёстой гэж заасан байдаг. 2018/2019 оны хичээлийн жилд ажиллаж буй цэцэрлэгийн үндсэн багш 170 хүнээс мэргэжлээр нь авч үзвэл 77 хувь буюу мэргэжлийн 131 багш ажиллаж байгаа бөгөөд 39 нь мэргэжлийн бус хүн байна.

Хувийн өмчийн 4 цэцэрлэгт 13 мэргэжлийн бус багш нар ажилладаг байна. Тухайлбал: Замын-Үүд сумын Ухаалаг багачууд цэцэрлэг 3 бүлэгтэй бөгөөд цэцэрлэгийн эрхлэгч сургуулийн өмнөх насны хүүхдийн багш мэргэжилтэй,

бүлгийн 3 багшийн нэг нь биеийн тамирын багш, дасгалжуулагч мэргэжилтэй, нөгөө нь баклавр зэрэгтэй монгол хэл, уран зохиолын багш, мөн Төгс боловсрол сургалтын төвийн сургалтад хамрагдсан туслах багшийн сертификаттай багш ажиллаж байна.

ЭМТ хуулийн 19.10.4-19.10.6 дугаар заалтын дагуу Эмийн сан, эмнэлгийн байгууллагууд нь төсөл ирүүлэхдээ галын аюулгүй байдлын дүгнэлт, мэргэшсэн боловсон хүчний мэдээлэл, ажлын байрны чанар ашиглалтын байдал, эрүүл ахуйн дүгнэлт, хөдөлмөрийн харилцаа үүсгэхийг зөвшөөрсөн зөвшөөрөл зэргийг шинээр бүрдүүлсэн хэдий ч үйл ажиллагааны явцад хугацаа дууссан дүгнэлтүүдийг тухай бүр шинэчлэн гаргуулаагүй байна. Мэргэжлийн боловсон хүчний хувьд Сайншанд, Замын-Үүд сумаас бусад сумдад боловсон хүчний хүрэлцээ дутмаг, тогтвор суурьшилгүй байгаагаас ажилласан жилийн туршлага нь шалгуур үзүүлэлтийг хангаагүй зэрэг асуудал түгээмэл байна. Сум орон нутгийн эмийн хэрэгцээг дангаараа хангадаг ЭЭС ОНӨААТҮГ-ын эмийн сангуудад эмийн хангалт дутмаг байдаг байна. Тухайлбал: Айраг сумын ЭЭС-ийн эмийн хангамж хүрэлцдэггүй талаар сумын ЭМТ-д удаа дараа гомдол ирсэн, иргэд шаардлагатай эм тариагаа цаг хугацаанд нь авч чаддаггүй хүндрэл үүссэн зэргээс харахад эмийн сангуудын санхүүгийн чадавх сул байгааг харуулж байна.

1.3 Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн бүртгэлийг сайжруулж олон нийтэд ил тод мэдээлэх хэрэгтэй байна.

1.3.1 Архи, тамхины тусгай зөвшөөрлийн хугацаа, хөдөлгөөн өөрчлөлт, тусгай зөвшөөрөл эзэмшигчийн гаргасан зөрчлийг нэгтгэн хянаж бүртгээгүй байна.

Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай хуулийн 14-т заасны дагуу өргөдөл бүртгэх, хянан шийдвэрлэх үйл ажиллагааг хэрэгжүүлдэг байна. 2017-2019 онд нийт 112 өргөдөл хүлээн авч өргөдөл бүртгэх дэвтэрт бүртгэн анхан шатны шүүлт хийхдээ өргөдөлд хавсаргасан бичиг баримтын бүрдлийг үзэж шалгаж, өргөдөл гаргасан талбай нь тусгай хэрэгцээ болон нөөцөд авсан, ашигт малтмал хайх, ашиглахыг хориглосон, хүчин төгөлдөр тусгай зөвшөөрлөөр олгогдсон талбайтай давхацсан эсэхийг тодруулж нийт ТТАМ хайх 11, хугацаа сунгах 2, ашиглах 4 тусгай зөвшөөрөл олгосон байна.

Хүснэгт №8

Д/д	Утга	2017 он	2018 он	2019 он	Шийдвэрлэсэн байдал
1	ТТАМ ашиглах тусгай зөвшөөрөл хүссэн	2	1	1	4 өргөдлийг дэмжиж шийдвэрлэсэн
2	ТТАМ хайх тусгай зөвшөөрөл хүссэн	28	29	45	Шинээр тусгай зөвшөөрөл олгосон 11
3	ТТАМ хайх тусгай зөвшөөрлийг сунгуулах	0	6	0	Хугацаа сунгасан 2
Нийт хүлээн авсан өргөдлийн тоо		30	36	46	2018 онд 1, 2019 онд 8

Бусад өргөдлийг анхан шатны зураг зүйн шүүлт болон АМГТГ-аас ирүүлсэн дүгнэлт, аймаг, сумын ИТХ-ын санал зэргийг үндэслэн тусгай зөвшөөрөл олгох боломжгүй, өргөдөл хүлээн авахаас татгалзсан тухай хариуг компаниудад хүргүүлж ажилласан байна.

Түгээмэл тархацтай ашигт малтмал хайх тусгай зөвшөөрөл эзэмших эрхийн хугацаа дууссан, БОМТ батлуулаагүй, тайлан ирүүлээгүй, тусгай зөвшөөрлийн төлбөр төлөөгүй, ашигт малтмалын кадастрын мэдээллийн санд бүртгүүлээгүй,

сунгуулах хүсэлт ирүүлээгүй шалтгаанаар 2017 онд 4, 2018 онд 2, 2019 онд 6 тусгай зөвшөөрлийг хүчингүй болгосон байна.

Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 6.4-т "Тусгай зөвшөөрлийн нөхцөл, шаардлагыг зөрчсөн тохиолдолд тусгай зөвшөөрлийн хугацааг сунгахгүй", аймгийн ИТХ-ын 2017 оны 06/05 дугаар тогтоолоор баталсан Согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрөл олгох, хяналт тавих журмын 6.8-д "Хүсэлт гаргагч нь урьд тусгай зөвшөөрөл эзэмшиж байх хугацаандаа аливаа зөрчил дутагдал гаргасны улмаас тусгай зөвшөөрлийг хүчингүй болгосон бол тухайн шийдвэр гарсан өдрөөс хойш 1 жилийн дотор дахин хүсэлт хүлээн авахгүй", 6.9-д "Худалдаа үйлчилгээ үзүүлэх тав тухтай орчин бүрдүүлсэн эсэх, урьд нь гарсан зөрчил дутагдлаа тухай бүрд зассан эсэх нь хугацаа сунгахад онцгой нөлөөлнө" гэж заасан. Мөн тусгай зөвшөөрөл шинээр олгох, сунгахтай холбоотой маргаантай асуудлыг 15 хоногийн дотор, тусгай зөвшөөрлийн хугацаа сунгах хүсэлтийг хугацаа дуусахаас 15 хоногийн өмнө аймгийн ЗДТГ-т ирүүлэх, мөн тусгай зөвшөөрөл шинээр олгох, хугацааг сунгахад татгалзах зүйл заалтын 7.1.7-д "Жилд нэгээс дээшгүй удаа архи тамхины хор уршиг сурталчлах ажилд оролцоогүй, оролцохоос татгалзсан" гэж заасан байна.

Тусгай зөвшөөрөл бүхий газруудын тусгай зөвшөөрөл анх авсан хугацаанаас хойш хэдэн жил согтууруулах ундаа худалдаж, түүгээр үйлчилж байгаа, хэдэн удаа тусгай зөвшөөрлөө сунгуулсан, тусгай зөвшөөрлийн ямар нөхцөл, шаардлагыг зөрчсөн тухай нэгтгэсэн мэдээлэл байхгүй байна. Аймгийн Засаг даргын тусгай зөвшөөрөл шинээр олгох, сунгах, хүчингүй болгох 2017 оны захирамжид хүчингүй болгосон шалтгаан нь тодорхойгүй байна. 2018-2019 оны захирамжид тусгай зөвшөөрлийн хугацаа дууссан боловч хүсэлтээ ирүүлээгүй гэсэн шалтгаанаар 18 цэгт үйл ажиллагаа явуулах тусгай зөвшөөрлийг хүчингүй болгосон байна.

Компанийн тусгай зөвшөөрлийг хүчингүй болгосноос хойш 3 хоногоос 4 сарын дотор шинээр 20 тусгай зөвшөөрөл олгосон байна. Тухайлбал:

Хүснэгт №9					
Д/д	ААНБ-ын нэр	Сумын нэр	Хүчингүй болгосон захирамжийн огноо	Дахин шинээр олгосон захирамжийн огноо	Хүчингүй болгосноос хойш дахин шинээр олгох хоорондын хугацаа
1	Бүрдэнэ булаг ХХК хүнсний дэлгүүр	Сайншанд	2018.04.24	2018.04.27	3 хоног
2	Өлгий эргэл ХХК зоогийн газар	Замын-үүд	2018.04.24	2018.04.27	3 хоног
3	Говь тайхар ХХК хүнсний дэлгүүр	Хөвсгөл	2017.12.14	2017.12.22	8 хоног
4	Боржигон туяа хоршоо хүнсний дэлгүүр	Даланжаргалан	2018.01.22	2018.02.01	8 хоног
5	Монгол тарвас кафе	Сайншанд	2019.05.09	2019.05.20	11 хоног
6	Их говийн баялаг ХХК хүнсний дэлгүүр	Замын-үүд	2019.07.03	2019.07.16	16 хоног

Тусгай зөвшөөрөл хүчингүй болгосонтой холбоотой маргаан гардаг хэдий ч тусгай зөвшөөрөлтэй холбоотой өргөдөл, гомдол, маргааныг бүртгээгүй, нотлох баримт байхгүй байгаа нь ямар шатандаа асуудал үүссэнийг тодорхойлох боломжгүй байна. Архины хор хөнөөлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр тусгай зөвшөөрөл бүхий ААНБ-тай хамтарч ажилласан, сурталчилсан талаарх судалгаа, мэдээлэл тодорхойгүй байна. Сумдын Засаг дарга нараас журмын хэрэгжилтийг хангуулан ажилласан тухай үр дүнгийн мэдээлэл ирүүлээгүй байна.

ААҮАТЗТ хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д хуульд өөрөөр заагаагүй бол тусгай зөвшөөрлийг 3 жилээс доошгүй хугацаагаар олгоно, 6.2-д тусгай зөвшөөрлийг хуульд өөрөөр заагаагүй бол анх олгосон хугацаанаас нь доошгүй хугацаагаар сунгаж болно гэж заасан. Тамхи худалдах тусгай зөвшөөрлийн хугацааг Сайншанд сум 3 жилээр, бусад сумд 2 жилийн хугацаатайгаар олгож, сунгаж байна.

ААҮАТЗТ хуулийн 6 дугаар зүйлийн 6.3-д “хэрэв хуульд өөрөөр заагаагүй, энэ хуулийн 13.1-д заасан нөхцөл байдал илрээгүй тохиолдолд зөвхөн зөвшөөрөл эзэмшигчийн өргөдлийг үндэслэн 3 хоногийн дотор тусгай зөвшөөрлийн хугацааг сунгана, 12 дугаар зүйлийн 12.1-д Тусгай зөвшөөрөл олгох эрх бүхий байгууллага нь тусгай зөвшөөрөл хүссэн өргөдөл, холбогдох бусад баримт бичгийг хянан үзэж, тусгай зөвшөөрөл олгох эсэх тухай асуудлыг хуульд өөрөөр заагаагүй бол өргөдөл хүлээн авснаас хойш ажлын 21 хоногийн дотор шийдвэрлэнэ” гэж заасан байдаг.

2018, 2019 онд тамхи худалдах зөвшөөрлийг 4 иргэн, 2 ААНБ-ын тусгай зөвшөөрлийн хугацаанд сунгалт хийхдээ хуульд заасан хугацааг баримтлаагүй, шийдвэрлэвэл зохих хугацааг хэтрүүлж олгосон байна.

Хугацаа хэтрүүлсэн хоногийн тоог харуулбал:

Хүснэгт №10

Д/д	Сумын нэр	Өргөдлийн огноо	Захирамжийн огноо	Хугацаа хэтрэлт /хоног/	Тайлбар
1	Замын-Үүд	2019.10.17	2019.11.08	12	Сунгалт
2	Сайншанд	2019.11.01	2019.11.22	12	Сунгалт
3	Сайншанд	2019.09.18	2019.10.14	15	Тусгай зөвшөөрлийн хугацаа 2019.07.06 дууссан байсан
4	Сайншанд	2019.10.21	2019.11.14	15	Сунгалт
5	Замын-Үүд	2019.10.11	2019.11.08	17	Сунгалт
6	Сайншанд	2018.10.31	2018.12.05	22	Тусгай зөвшөөрлийн хугацаа 2018.07.06 дууссан байсан

Тусгай зөвшөөрлийг сунгах үйл ажиллагааг хуулийн хүрээнд шийдвэрлээгүйгээс иргэд, ААНБ нь тусгай зөвшөөрлийн хугацаа дууссан байхад үйл ажиллагаагаа явуулж зөрчилд орох эрсдэлтэй байна.

Сумд тамхины тусгай зөвшөөрлийг шинээр авч байгаа тохиолдолд хуулийн хугацаанд буюу ажлын 21 хоногийн дотор шийдвэрлэж байна.

ААҮАТЗТ хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-д “тусгай зөвшөөрлийн хугацаа, нөхцөл, шаардлагыг зөрчсөн тохиолдолд мэргэжлийн хяналтын байгууллагын дүгнэлтийг үндэслэн тусгай зөвшөөрлийг олгосон байгууллага түүнийг 3 сар хүртэл хугацаагаар түдгэлзүүлж болно” гэж заасан байдаг. Тамхины тусгай зөвшөөрлийг нь түдгэлзүүлсэн, хүчингүй болгосон иргэн, ААНБ байхгүй байна.

Боловсролын тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.1-д тусгай зөвшөөрлийг 5 жилээс доошгүй хугацаагаар олгоно гэж заасан байдаг. Аймгийн Засаг дарга 2017 онд Гурван билэг цэцэрлэг, 2019 онд Болор-Эрдэнэ, Ухаалаг багачууд цэцэрлэгийн тусгай зөвшөөрлийг сунгасан байна. Жаргалан цэцэрлэг 2015 онд 5 жилийн хугацаатай тусгай зөвшөөрөл олгогдсон байна.

Замын-Үүд сумын Үлэмж тэнгэр сургууль нь 2017-2022 он хүртэл тусгай зөвшөөрлөө сунгасан байсан бөгөөд 2019 онд сургуулийн бүтэц зохион байгуулалт “бага сургууль” болж өөрчлөгдсөн тул тусгай зөвшөөрөлд өөрчлөлт оруулсан байна.

Тусгай зөвшөөрөлтэй төр, хувийн хэвшлийн ЭМБ-ын судалгааг жил бүр гарган, нэмэлт өөрчлөлтүүдийг тусган баяжуулж, нэгтгэл гаргаж ажилласан байна.

1.3.2 Тусгай зөвшөөрөлтэй холбоотой үйл ажиллагааны талаар ил тод мэдээлэх хэрэгтэй байна.

Дорноговь аймгийн <http://dornogovi.gov.mn/> вэб сайтад согтууруулах ундаа, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрөл олгох Засаг даргын захирамж гарсан тухай бүр сум, аймгийн хэмжээнд тусгай зөвшөөрөл бүхий ААНБ-ын жагсаалтыг гаргаж байршуулсан байна. Тухайлбал: аймгийн Засаг даргын захирамжаар тусгай зөвшөөрөл шинээр олгосон, хүчингүй болгосон, байршил өөрчилсөн, хугацааг сунгасан мэдээллийг тухай бүр оруулж хэвшсэн байна.

Тухайн аж ахуйн нэгжийн зөвшөөрөл эзэмшиж байх хугацаанд зөрчил дутагдал гаргаж байсан талаарх мэдээллийг мэргэжлийн байгууллагуудын нэгдсэн төв цахим сангаас тухай бүрд тодруулга авдаг гэсэн хэдий ч тусгай зөвшөөрөл олгохтой холбоотой үүсгэсэн архивын нэгжид нотлох баримтыг хавсаргаагүй байна.

Аймгийн ИТХ-ын 2017 оны 06/05 дугаар тогтоолоор Согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрөл олгох, хяналт тавих журмын 2.4-д "Сумын Засаг дарга энэхүү журмын хэрэгжилтийг хангуулан ажиллаж үр дүнгийн талаарх мэдээллийг хагас жил тутамд ирүүлнэ" гэж заасан байхад сумдын Засаг даргаас журмын хэрэгжилтийг хангуулан ажилласан тухай мэдээллийг журамд заасан хугацаагаар ирүүлээгүй байна.

ТҮИХҮХТ журмын 6.1-д сумын Засаг дарга, мэргэжлийн хяналт, цагдаа, гааль, татварын байгууллага бүр тамхины худалдаа, үйлчилгээтэй холбоотой зөрчлийн талаарх иргэдийн мэдээлэл, гомдол, санал хүлээн авах нээлттэй утсыг олон нийтэд зарлан тогтмол ажиллуулна гэж заасан байдаг.

Сайншанд сумын ЗДТГ 70523737, Замын-Үүд сумын ЗДТГ 70527007, МХГ 70522352 утсаар иргэдийн мэдээлэл, гомдол, санал хүлээн авах утсыг ажиллуулж байна. Тамхины тусгай зөвшөөрөлтэй холбоотой иргэд, ААНБ-аас ирсэн өргөдөл, гомдол байхгүй байна. Сайншанд сумын ЗДТГ нь цахим хуудсандаа “зөвшөөрөл” гэсэн цэстэй, 2015 онд тамхины тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн мэдээллийг 1 удаа оруулсан байна. Үүнээс хойш мэдээлэл байршуулаагүй байна.

Зураг №1



Зураг №2



Бусад сумд тамхи худалдах тусгай зөвшөөрөл олгосон байгууллагуудын талаар мэдээллийг ил тод мэдээлээгүй байна.

Тусгай зөвшөөрлийн комиссын гишүүдийн мэдээлэл, ЭМБ-ын дэлгэрэнгүй судалгаа болон олгосон, сунгасан, хүчингүй болсон, нэмэлт өөрчлөлт оруулсан захирамжуудыг тусгай самбар, аймгийн ЭМГ-ын цахим хуудсанд, аймгийн ЗДТГ-ын <http://dornogovi.gov.mn/> цахим хаягт тус тус ил тод байршуулсан байна. Гэвч тусгай зөвшөөрлийн комиссын ажлын алба нь Эрүүл мэндийн яамны <http://licemed.mohs.mn/> цахим программын "Тусгай зөвшөөрөлтэй байгууллага" хэсэгт тусгай зөвшөөрөлтэй ААН-ийн мэдээллийг ил тод байршуулаагүй байна.

БҮЛЭГ2.Тогтоосон шаардлага, стандарт баримтлаагүй байгууллагуудтай ажиллах арга барилаа өөрчилж хууль эрх зүйд нийцүүлж ажиллах шаардлагатай байна.

2.1 Тусгай зөвшөөрөл эзэмшигчид аж ахуйн үйл ажиллагаанд мөрдөх шаардлагуудыг биелүүлээгүй байна.

2.1.1 Аж ахуйн үйл ажиллагаанд стандарт, дүрэм журмыг хэрэгжүүлээгүй байна.

АИТХ-ын 2017 оны 06/05 дугаар тогтоолоор баталсан Согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрөл олгох хяналт тавих журмын 4.1.11-т "Үндсэн ажилтан нь хөдөлмөрийн гэрээ байгуулсан, нийгмийн даатгал төлдөг, тогтвор суурьшилтай ажиллах нөхцөлөөр хангагдсан, харилцааны өндөр соёлтой, мэргэжлийн үнэмлэхтэй, эрүүл мэндийн шинжилгээнд хамрагдсан, ажилтны нэр бүхий энгэрийн тэмдэг, нэрийн хуудас, иж бүрэн хувцастай байх", 4.1.9-д "Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд үйлчлэх зориулалтын тохижилт хийгдсэн байх" гэж заасан байна.

Аудитаар Сайншанд, Замын-Үүд, Айраг, Даланжаргалан, Иххэт сумын согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрөлтэй 43 ААНБ-аар явж хуулиар хүлээсэн үүргээ биелүүлж буй эсэхийг үзэхэд бүх байгууллагад мэргэжлийн байгууллагуудаас гаргасан дүгнэлтүүд бүрэн, хүчинтэй, /тусгай зөвшөөрөл, тохирлын гэрчилгээ, галын аюулгүй байдлын дүгнэлт/ НӨАТ-ын Е баримтыг олгож хэвшсэн байв. Харин дараах шаардлагыг бүрэн хангасан газар байхгүй байна. Тодруулбал: Хөгжлийн бэрхшээлтэй иргэнд үйлчлэх зориулалтын тохижилт хийгдээгүй 23, авто зогсоолгүй 19, хуулийн самбар, сурталчилгааны зурагт хуудас байрлуулаагүй 15 ААНБ байсан ба 10-аад ААНБ ажиллагсадтай хөдөлмөрийн гэрээ байгуулаагүй, НДШ төлөөгүй, эрүүл мэндийн шинжилгээнд хамрагдаагүй, мэргэжлийн үнэмлэхгүй, энгэрийн тэмдэггүй, гадна хаяг, цагийн хуваарь, гэрэлтүүлэггүй зэрэг нийтлэг зөрчилтэй байв.


Тусгай зөвшөөрөл эзэмшигчид өөрийн үйл ажиллагаатай холбоотой хууль, эрхзүйн акт, дүрэм журмын мэдлэг хангалтгүй, үүргээ биелүүлэх талаар ухамсарладаггүйгээс согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэхтэй холбоотой хууль, эрх зүйн шаардлагад нийцүүлж үйл ажиллагаагаа явуулаагүй байна.

Аудитын явцад тамхи худалдах тусгай зөвшөөрөлтэй Айраг суманд 5, Даланжаргалан суманд 5, Замын-Үүд суманд 5, Сайншанд суманд 10 дэлгүүрийг түүвэрлэн шалгахад дараах зөрчил дутагдлууд илэрлээ. Үүнд:

ТХТ хуулийн 6 дугаар зүйлийн 6.7.7-д 21 нас хүрээгүй хүнд тамхи худалдах, түүгээр тамхи худалдуулахыг хориглоно гэж заасан байдаг. Айраг сумын 1, Даланжаргалан сумын 1 дэлгүүрт 21 насанд хүрээгүй худалдагч тамхи худалдаж байсан.

ТХТ хуулийн 6 дугаар зүйлийн 6.7.14-д “ерөнхий боловсролын сургуулийн хичээлийн болон дотуур байраас 500 метрийн дотор тамхи худалдахыг хориглоно”, ТҮИХҮХТ журмын 5.1.4-д “ЕБС-ийн хичээлийн болон дотуур байрнаас 500 метрийн доторх зайг тодорхойлсон зураглалыг сумын ЗДТГ-аар баталгаажуулсан баримт гаргуулсан байх” гэж заасан байдаг. Замын-Үүд сум ЕБС-ийн хичээлийн болон дотуур байрнаас 500 метрийн доторх зайг тодорхойлсон зураглалыг сумын ЗДТГ-ын газрын даамлаар баталгаажуулсан байна.

Зураг №3



Замын-Үүд сум

Зураг №4



Сайншанд сум

Сайншанд сум google map ашиглан зайг тодорхойлдог байна. Даланжаргалан сум мотоциклоор зайг хэмждэг гэсэн тайлбарыг өгсөн. Харин Айраг, Даланжаргалан, Өргөн сум баталгаажуулсан зураглал байхгүй.

ААҮАТЗТ хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.6-д үйл ажиллагаа явуулах барилга байгууламжийн гаднах орчны аюулгүй байдлыг хангах зорилгоор дүрс бичлэгийн техник, хэрэгсэл суурилуулж, энэ талаар цагдаагийн байгууллагын саналыг авсан байх гэж заасан байдаг.

Ихэнх дэлгүүрүүд камержуулалт хийгдсэн, Даланжаргалан сумын 2, Сайншанд сумын 2 дэлгүүрт дүрс бичлэгийн камер байхгүй байна.

ТҮИХҮХТ журмын 5.1.3-д тамхийг худалдааны байгууллагын кассын дэргэд байрлуулахгүйгээр тусгайлсан лангуугаар худалдаалах гэж заасан байдаг.

Зураг №5



Зураг №6



Гэтэл энэ заалтыг Айраг, Сайншанд сум тус бүрд нэг дэлгүүр хэрэгжүүлээгүй байна.

Иххэт, Даланжаргалан, Айраг сумдын ЭМТ-д их засвар, өргөтгөл хийгдсэн боловч барилгын ашиглалтын чанар байдлын дүгнэлтээ гаргуулаагүй, Айраг, Даланжаргалан сумын ЭМТ-ийн цахилгааны утас ил гарсан, щитний холболт нь аюулгүй ажиллагааг зөрчсөн, хэвтэн эмчлүүлэх тасгийн шатны дэргэд байрлуулсан зэрэг нь эрүүл мэндийн байгууллагын орчны шаардлагад нийцэхгүй байна. ЭМТ-ийн эмч нар эмийн нянгийн тэсвэржилт, хор уршгийн талаарх тусгайлсан сургалтад хамрагдаагүй, мөн эм хэрэгслээ зориулалтын бус тээврийн хэрэгслээр тээвэрлэж байна. Тухайлбал: Өөрсдийн унаа, гар тээш, сумынхаа иргэдээр дайж авчруулдгаас өвлийн улиралд эм тариа хөлдөж ирэх нөхцөлийг бүрдүүлж байна.

Айраг, Даланжаргалан, Иххэт, Замын-Үүд сумын ЭЭС, Монос-Дорноговь ХХК-ний Сайншанд, Айраг суман дахь Эмийн сангуудад зайлшгүй шаардлагатай эмийн нөөц 90 хувьд хүрэхгүй, барилгын ашиглалтын чанар байдлын дүгнэлт гаргуулаагүй, эм зүйч нар менежментийн сургалтад хамрагдаагүй байна. ЭЭСан ОНӨААТҮГ-ын харьяа эмийн сангууд нь ариутгал халдваргүйтгэлийн талаар холбогдох байгууллагатай гэрээ байгуулж ажиллаагүй, тогтсон тээврийн хэрэгслээр эм, эмнэлгийн хэрэгсэл тээвэрлэх гэрээ байгуулаагүй, галын аюулгүй байдлын дүгнэлт гаргуулаагүй, ХБИ, өндөр настанд чиглэсэн бодлого, үйл ажиллагаа байхгүй, ажлын байрны түрээсийн гэрээ болон үл хөдлөх хөрөнгийн гэрчилгээний хуулбар байхгүй зэрэг зөрчил нийтлэг байна. Эмийн нөөцөө зөв тооцоолдоггүй, захиалгаа тогтмол өгдөггүй, зайлшгүй шаардлагатай эмийн хэрэгцээ шаардлага бага, борлуулалтаар байнга гардаггүй эм олон багтдагаас шалтгаалж эмийн нөөц 90 хувиас доош байна. Энэ байдал нь эмийн хомсдол үүсэх, хөнгөлөлттэй жороор олгох эмийг хугацаанд нь олгож чадахгүй байдалд хүрэхэд нөлөөлж байна.

2.1.2 Тусгай зөвшөөрөл эзэмшигчид хуулиар хүлээсэн үүргээ биелүүлээгүй байна.

ТТАМ-ын тухай хуульд тусгай зөвшөөрөл эзэмшигч нь дараах мэдээ, тайланг доор дурдсан хугацаанд аймаг, нийслэлийн Засаг даргад ирүүлнэ: Үүнд “Хайгуулын ажлын жилийн тайланг төрийн захиргааны байгууллагаас баталсан маягтын дагуу, хайгуулын үе шатаар нь ангилан гаргаж, тайланг гаргасан хугацаанаас хойш 60 өдрийн дотор”, ТТАМ-ын ашиглалтын тухайн ордыг ашиглах техник, эдийн засгийн үндэслэлийг ашиглалтын тусгай зөвшөөрөл авснаас хойш 120 өдрийн дотор; дараа жилийн үйлдвэрлэлийн үндсэн үзүүлэлтийг жил бүрийн 12 дугаар сард багтаан батлагдсан маягтын дагуу; тухайн жилийн үйл ажиллагааны тайлан, маркшейдерийн хэмжилтээр тогтоогдож батлагдсан уулын ажлын үндсэн үзүүлэлт болон график зургийг дараа оны 02 дугаар сарын 15-ны өдрийн дотор батлагдсан маягтын дагуу гаргаж ирүүлнэ. ТТАМ-ын хайгуулын тусгай зөвшөөрөл эзэмшигчид эдгээр заалтуудыг хэрэгжүүлээгүй, мэдээ тайланг ЗД-д ирүүлээгүйгээс тусгай зөвшөөрлөө хүчингүй болгуулсан байна. Мөн ТТАМ ашиглах тусгай зөвшөөрөл бүхий зарим компани мэдээ тайланг хугацаанд нь ирүүлээгүй байна.

АИТХ-ын 2017 оны 06/05 дугаар тогтоолоор баталсан Согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрөл олгох хяналт тавих журмын дагуу өөрийн үйл ажиллагаатай холбоотой хууль тогтоомж, стандарт, аймгийн нутаг

дэвсгэрт нийтээр дагаж мөрдүүлэхээр гарсан дүрэм, журам, төрийн захиргааны болон өөрөө удирдах байгууллагаас гаргасан шийдвэрийг чанд биелүүлж ажиллана гэсэн үүргээ биелүүлээгүй, шинээр үйл ажиллагаа эхлүүлэх хөрөнгө оруулалт хийхийн өмнө аймгийн ЗДТГ-ын ХОХБХ, МХГ, СХЗХ болон бусад мэргэжлийн байгууллагаас сургалт, зөвлөгөө аваагүй байна.

Сайншанд суманд тусгай зөвшөөрөлгүй тамхи худалдаж байсан 1 хүнсний дэлгүүр, гэр хороололд байршилтай 2 дэлгүүр байсан бөгөөд хуулийн дагуу тусгай зөвшөөрөл авахыг санууллаа.

Үйл ажиллагаа явуулах байршлыг дур мэдэн өөрчилсөн тамхины тусгай зөвшөөрөлтэй ААНБ байхгүй байна. Сайншанд сумын тусгай зөвшөөрөлтэй 1 дэлгүүр хүсэлт тавьж байршлаа өөрчилсөн байна.

Тамхины зүй зохистой хэрэглээг тусгай зөвшөөрөлтэй иргэн, ААНБ-ууд сурталчлахгүй байгаа бөгөөд зарим дэлгүүрүүдэд мэдээллийн самбар байхгүй байна.

Аймгийн болон Замын-Үүд сумын нэгдсэн эмнэлэг нь галын аюулгүй байдлын дүгнэлтээ сунгуулаагүй, нэгдсэн эмнэлэг, Өрхийн ЭМТ-ийн эмчийн бичсэн алдаатай жорын тоо их, сумын эмийн сангууд нь стандартад заасан хүний нөөцөөр бүрэн хангагдаагүй, зохистой жор бичилтийг төлөвшүүлэхийн тулд харьяа нутаг дэвсгэрийн эмнэлгийн мэргэжилтэнтэй хамтарч ажилладаггүй, эмийн сан, эмнэлгийн багаж тоног төхөөрөмжид жил бүр үзлэг тохиргоо хийж баталгаажуулдаггүй байна. ЭМТ-үүд батлагдсан орон тоо байхгүйгээс эм зүйчгүй байна. Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь тэргүүлэх чиглэлийн дагуу төсөл ирүүлээгүй, бүрдүүлэх баримт бичигт тавигдах шаардлагыг хангаагүй, шалгарсан төслийн дагуу стандарт хангасан үйлчилгээ явуулаагүй байна.

Даланжаргалан сумын Олон-Овоо багт эмийн сан байгуулах 2 төсөл ирүүлсэн ч ЭЭС-ийн төсөл эхэлж ирсэн гэх шалтгаанаар тусгай зөвшөөрлийн комисс хувийн эмийн сангийн төслийг буцааж, ЭЭС-ийн төсөлд шинжээч томилохоор шийдвэрлэсэн байна. ЭЭС нь 2 хүний бүрэлдэхүүнтэйгээр үйл ажиллагаа явуулахаар хүний нөөцөө бүрдүүлж, гэрээ байгуулсан хэдий ч, эм зүйч шилжин явснаас болж үйл ажиллагаа зогссон байна.

Айраг сумын Монос эмийн сангийн төсөлд 3 хүн ажиллуулахаар тусгасан байна. Гэвч тус эмийн санд боловсон хүчний ажилласан жилийн шаардлагад нийцээгүй эрхлэгч, эм найруулагч-1 туслах ажилтан-1 ажиллаж бөгөөд эм зүйч томилоогүй байна. Эмийн сангийн зориулалтаар ашиглахаар МХГ-аас дүгнэлт гарсан Эмийн сангийн байранд хүүхдийн тоглоом, барааны лангуу давхар нээж туслах ажилтныг худалдагчаар ажиллуулсан байна. Энэхүү зөрчлийг арилгуулахаар тусгай зөвшөөрлийн комисст хариуцуулж нэг албан шаардлага бичив.

Замын-Үүд сумын Монсей-Джи шүдний эмнэлэг нь төсөлд тусгагдсан гэрээ байгуулсан эмч нарыг ажиллуулаагүй, гэрээ байгуулсан эмч нь тогтвор суурьшилтай ажиллахгүйгээр шилжин явсан байна. Тус эмнэлэгт нэгдсэн эмнэлгийн шүдний эмч хавсран гүйцэтгэж байгаа гэх боловч ажил хавсран гүйцэтгэхийг зөвшөөрсөн захирлын тушаал шийдвэргүй байна. Ажлын байр нь галын аюулгүй байдлын дүгнэлтгүй, эмийн нөөц бий болгосон ч хугацаат эмийн хяналтын самбар байршуулж бүртгэл хөтлөөгүй, барилгын ашиглалт, чанар, эрүүл

ахуйн дүгнэлтгүй, ажлын байрны түрээсийн гэрээгээ шинэчлүүлж баталгаажуулаагүй байна.

2.2 Тусгай зөвшөөрөл бүхий ААНБ-д хяналт хэрэгжүүлж байгаа хэдий ч тэдгээрийн хариуцлагагүй байдал, хууль эрх зүйн мэдлэг дутмагаас зөрчил арилахгүй байна.

2.2.1 Шаардлага хангаагүй бүх цэгүүдэд тусгай зөвшөөрлийг хүчингүй болгож дорвитой арга хэмжээ аваагүйгээс хяналтаар илэрсэн зөрчилд өгсөн зөвлөмж хэрэгжихгүй, хяналт шалгалтын үр дүнг хангалтгүй болгож байна.

Согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрөл олгох, хяналт тавих журмын 1.5-д "Энэхүү журмыг хэрэгжүүлэх ажлыг аймгийн ЗДТГ, цагдаагийн газар, МХГ, сумдын ЗД нар зохион байгуулж хэрэгжүүлнэ", тусгай зөвшөөрөл олгох, хяналт тавих эрх бүхий байгууллагуудын үүрэг 2.7-д "Архинд донтох өвчтэй иргэдийг эмчлүүлэх, эрүүлжүүлэх, нийгэмшүүлэхтэй холбоотой ажлыг холбогдох төрийн бус байгууллага, тусгай зөвшөөрөлтэй аж ахуйн нэгжтэй хамтран шийдвэрлэх асуудлыг хариуцан зохион байгуулна" гэж тусгасан байна. Тусгай зөвшөөрөл олгох, хяналт тавих эрх бүхий байгууллагуудаас Согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрөл олгох, хяналт тавих журамд заасны дагуу тусгай зөвшөөрөлтэй ААН-тэй хамтарч архинд донтох өвчтэй иргэдийг эмчлүүлэх, эрүүлжүүлэх, нийгэмшүүлэхтэй холбоотой ажил зохион байгуулсан тухай тайлан, баримт материал байхгүй байна.

Аймгийн ХОХБХ-ийн мэргэжилтэн согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрөл олгосон ААНБ улсын тэмдэгтийн хураамжийг тогтоосон тарифын дагуу төлсөн эсэхийг бүртгэлээр хянаагүй байна. Мөн ААНБ-ын улсын тэмдэгтийн хураамж төлсөн төлбөрийн баримтыг тухайн байгууллагын бүрдүүлсэн бичиг баримтын хамт архивын баримтад бүрэн хавсаргаагүй байна. Аудитаар Татварын хэлтэст 2017-2019 онуудад тусгай зөвшөөрөл авсан, сунгуулсан ААНБ-ын нэрсийг гарган өгч тус ААНБ-ууд улсын тэмдэгтийн хураамжийг хэдний өдөр, хэдэн төгрөг төлсөн тухай нотолгоо авахыг зорьсон боловч ААНБ-ын нэрсээр улсын тэмдэгтийн хураамж төлсөн жагсаалтыг гаргаж ирүүлээгүй болно. Эдгээрээс шалтгаалж тусгай зөвшөөрөл бүхий ААНБ тэмдэгтийн хураамжийг хэд хоногийн дотор төлсөн, төлбөл зохих дүнгээр төлсөн эсэхийг нотлох боломжгүй байна.

Аймаг, суманд шинэ жилийн баяр, цагаан сарын баяр, хүүхдийн эрхийг хамгаалах өдөр, улсын баяр наадмыг тэмдэглэхийн өмнөх үеэр МХГ-аас худалдаа үйлчилгээний чиглэлээр, хүнсний аюулгүй байдлыг хангах, урьдчилан сэргийлэх хяналт шалгалтыг тогтмол хийсэн байна.

Мөн сумдын цагдаагийн хэсгийн төлөөлөгч, татварын байцаагч, ХАА-н тасгийн мэргэжилтэн гэрэлтүүлэг, камержуулалт, НӨАТ-ын Е баримт олгож буй эсэхэд хяналт хийсэн байна.

Замын-Үүд сумын Засаг даргын 2019 оны А/324 захирамжаар томилогдсон ажлын хэсэг архи согтууруулах ундаагаар үйлчлэх тусгай зөвшөөрөлтэй газруудад заавал байршуулах шаардлагатай кассын машин, камергүй 8 газар, стандартын хэрэгжилт хангалтгүй, талбайн хэмжээний шаардлага хангахгүй, мэдээ мэдээллийн самбар байхгүй зэрэг түгээмэл зөрчил илэрснийг стандартын шаардлага хангуулах хугацаатай үүрэг даалгавар өгч ажилласан байна. Мөн ажиллагсдын эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулдаггүй, ажилчин албан хаагчид

ажлын байранд ажлын хувцас өмсөж хэвшээгүй, цэвэрлэгээ үйлчилгээг тогтмолжуулаагүй, худалдаа үйлчилгээг мэргэжлийн болон мэргэшсэн хүн эрхэлдэггүй, ариутгал, халдваргүйтгэл хийгдээгүй байсан байна.

Аймгийн Засаг даргын 2017 оны А/20 дугаар захирамжаар ажлын хэсэг байгуулж аймгийн хэмжээнд согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрөл эзэмшиж буй аж ахуйн нэгжүүдийн үйл ажиллагаанд хяналт шалгалт зохион байгуулж хяналтаар нийтлэг илэрсэн зөрчил нь дотоод хяналт сул, цэвэрлэгээ үйлчилгээг тогтмол хийж хэвшээгүй, барилга байгууламж нь стандартад нийцэхгүй, хаяг шошго стандартын дагуу хийгдээгүй, хадгалалтын хугацаа дууссан, хямд үнэтэй, гарал үүсэл нь тодорхойгүй согтууруулах ундаа худалдан борлуулсан байна. Шалгалтын дүнд үндэслэн 35 ААНБ-ын тусгай зөвшөөрлийг 3 хүртэл сараар түдгэлзүүлэх, 41 ААНБ-ын тусгай зөвшөөрлийг цуцлах санал оруулсан бөгөөд аймгийн Засаг даргын 2017 оны 4 сарын 18-ны өдрийн А/302 тоот захирамжаар 23 ААНБ-ын тусгай зөвшөөрлийг хүчингүй болгосон байна.

Шаардлага хангаагүй цэгийн тусгай зөвшөөрлийг хүчингүй болгож, үр дүнтэй ажиллаагүйгээс хяналтаар илэрсэн зөрчилд өгсөн зөвлөмж хэрэгжихгүй, хяналт шалгалтын үр дүн хангалтгүй байна.

Аймгийн ЗД-ын захирамжаар тусгай зөвшөөрлийг шинээр олгох, сунгах, хүчингүй болгох, үйл ажиллагааны чиглэлд өөрчлөлт оруулах бүрд ЭМБ, ААН-ийн үйл ажиллагаанд байнгын хяналт тавьж, мэргэжил арга зүйгээр хангаж ажиллахыг сумдын Засаг даргад үүрэг болгосон ч Замын-Үүд сумаас бусад сум биелүүлээгүй байна. Замын-Үүд сумын нийгмийн бодлогын тасаг нь 2018 онд удирдамж гарган 4 эмнэлэг, 5 эмийн санд хяналт шалгалт, зөвлөн туслах ажлыг зохион байгуулж, биелэлтийг хангуулан ажилласан байна.

Эрүүл мэндийн тухай хуулийн 11.2-т “Сум, дүүрэг, баг, хорооны Засаг дарга эрүүл мэндийг хамгаалах, дэмжих талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ”, 11.2.1-д “эрүүл мэндийн тухай хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдуулан Засгийн газар, нутгийн өөрөө удирдах байгууллага, дээд шатны Засаг даргаас гаргасан шийдвэрийн биелэлтийг харьяалах нутаг дэвсгэртээ зохион байгуулах” гэж заасан байна. Гэтэл аймгийн Засаг даргын захирамжаар эрүүл мэндийн тусгай зөвшөөрөл эзэмшигч байгууллагуудад байнгын хяналт тавьж, мэргэжил арга зүйгээр хангаж ажиллахыг сумдын Засаг дарга нарт үүрэг болгосон ч сумдад эрүүл мэндийн байгууллагуудад хяналт хийх тухай баталсан төлөвлөгөө, хэрэгжүүлсэн хяналт шалгалтын тайлан, мэргэжил арга зүйгээр хангаж ажилласан тухай баримт материал байхгүй байна.

ТХТ хууль тогтоомжийн биелэлтэд тавих хяналтыг ТХТ хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1-д ТХТ хууль тогтоомжийн биелэлтэд тавих төрийн хяналтыг бүх шатны Засаг дарга, мэргэжлийн хяналтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага, цагдаа болон хууль тогтоомжоор эрх олгогдсон бусад байгууллага, албан тушаалтан тус тусын эрх хэмжээний дагуу хэрэгжүүлнэ гэж заасан байдаг.

ТХТ хуулийн хэрэгжилтээр 2019 онд Айраг сум 3, Өргөн сум 1, Даланжаргалан сум 4, Замын-Үүд сум 4, Сайншанд сум 2 удаа хяналт шалгалтыг явуулсан байна. Хяналт шалгалтын тайлангаас харахад тамхины тусгай зөвшөөрөлтэй холбоотой илэрсэн зөрчилгүй байна.

Аймгийн Цагдаагийн газар нь 2019 оны 02 дугаар сард ТХТ хуулийн хүрээнд ширхгээр тамхи худалдан борлуулсан 1 иргэнээс 10 төрлийн 99 ширхэг тамхийг хураан авсан байна. Хураасан тамхийг Сайншанд сумын Засаг даргын дэргэдэх Орон тооны бус зөвлөл устгал хийсэн байна.

Замын-Үүд сум дахь Сум дундын Цагдаагийн хэлтэс нь 2017 онд ТХТ хуулийн хүрээнд тусгай зөвшөөрөлгүй тамхи худалдан борлуулсан 5 иргэнээс 129 хайрцаг, 2018 онд 2 иргэн, 4 ААНБ-аас 109 хайрцаг тамхи, 2019 онд 1 иргэн, 5 ААНБ-аас 51 хайрцаг тамхи хураан авсан байна. Хураасан тамхийг Замын-Үүд сумын Засаг даргын дэргэдэх Захиргааны зөвлөл худалдан борлуулж 2017 онд 273.9 мянган төгрөг, 2018 онд 339.1 мянган төгрөг, 2019 онд 152.7 мянган төгрөгийг орон нутгийн төсвийн орлого болгосон байна.

МХЕГ-ын даргын баталсан 2019 оны 01/31 дугаартай удирдамжийн хүрээнд аймгийн МХГ-ын 2019.01.23-08.30-ны хооронд хийсэн “Тамхи, тамхин бүтээгдэхүүн худалдаалах, сурталчлахад тавигдах шаардлагыг зөрчихөөс урьдчилан сэргийлэх хяналт хийсэн тухай танилцуулгад:

- Зөвшөөрөгдсөн цэгээс бусад газарт тамхины худалдаа, үйлчилгээ эрхлэх, тамхийг ширхгээр гудамж талбайд, гар дээрээс болон дуудлагаар хүргэх үйлчилгээгээр худалдаа хийх, баар цэнгээний газар, интернэтээр тамхи худалдах үйл ажиллагаа явагдаагүй байна.
- Ерөнхий боловсролын сургуулийн хичээлийн байр болон дотуур байрнаас 500 метрийн дотор тамхи худалдах цэг байхгүй болно.
- Тамхи худалдаалж буй 39 объект “Аж ахуйн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн тухай” хуулийн 16 дугаар зүйлийн 16.3.4 дэх заалтад заасан тусгай зөвшөөрлийг 100% авч, үйл ажиллагаа явуулж байна.
- “Тамхины хяналтын тухай” хуулийн 6 дугаар зүйлийн 6.7.11, 6.8.1 дэх заалтыг зөрчсөн, тамхины ил, далд сурталчилгаа явуулах, аливаа хэлбэрийн урамшуулалт худалдаа, сугалаа зохион байгуулсан зөрчил илрээгүй байна.

Харин нийтийн хоол, худалдаа, бар цэнгээний газарт утаат тамхи татах зөвшөөрөгдсөн цэг байгуулаагүй, худалдаа үйлчилгээний байгууллагууд тамхины хяналтын арга хэмжээг хэрэгжүүлэх, тамхины хор нөлөөний талаар иргэдийг мэдээллээр хангах үйл ажиллагааг хэрэгжүүлээгүй, аж ахуйн нэгжийн дотоод журамд тамхины үйл ажиллагаатай холбогдсон зохицуулалтыг тусгаж хяналт тавиагүй, тамхи татахыг хориглосон анхааруулах тэмдгийг шаардлагатай газруудад байрлуулаагүй зэрэг зөрчил нийтлэг илэрсэн байна.

Дорноговь аймгийн эмнэлгүүдэд хяналт шалгалт хийх тухай МХЕГ-ын удирдамжаар 2019 онд Сайншанд сумын 7 эмнэлэг Замын-Үүд сумын 4 эмнэлэг нийт 11 эмнэлэгт төлөвлөгөөт хяналт шалгалт явуулж албан шаардлага хүргүүлсэн бөгөөд ӨЭМТ-ийг сонгон авч зөвлөн туслах үйлчилгээ үзүүлсэн байна.

2.2.2 Байгууллагууд тусгай зөвшөөрлийн хугацаандаа стандарт дүрэм журмаа мөрдөж, хяналтаар өгсөн зөвлөмжийг тууштай хэрэгжүүлэх хэрэгтэй байна.

Мэргэжлийн байгууллагууд хамтран тусгай зөвшөөрөл бүхий ААНБ-д томоохон баяр ёслолын өмнө жил бүр үзлэг шалгалт хийж зөрчил илрүүлж арга хэмжээ авдаг хэдий ч хариуцлага сул, хууль эрх зүйн мэдлэг хангалтгүйгээс дийлэнх компаниуд зөвлөмжийг тогтмол хэрэгжүүлж ажиллаагүй байна.

МХГ нь 2019 онд тамхи худалдах тусгай зөвшөөрөлтэй 39 объектод хяналт шалгалт хийсэн ба тус шалгалтаар нийт 32 зөрчил илрүүлж, 26 зөрчил буюу 81%-ийг газар дээр нь арилгуулж, зөрчил арилгах 11 заалт бүхий 5 албан шаардлагыг 5 байгууллагад хүргүүлсэн байна. Албан шаардлагын хэрэгжилтийг ирүүлсэн байна.

Эмийн чанар аюулгүй байдлыг хангах тухай МХЕГ-ын удирдамжаар 2017 онд хийгдсэн хяналт шалгалтаар Сайншанд, Мандах, Улаанбадрах, Хөвсгөл, Өргөн, Эрдэнэ, Замын-Үүд сумдад байрлаж үйл ажиллагаагаа явуулж буй 10 эмийн санд албан шаардлага зөвлөмж өгснийг хэрэгжүүлж ажилласан байна. Эмийн сангууд нь эмийн сангийн өдөр тутмын үйл ажиллагаанд тавих дотоод хяналтыг сайжруулж, эм эмнэлгийн хэрэгсэл татан авах, хадгалах, олгох журам баталж, мөрдүүлэн, эмийн гаж нөлөөний талаар ӨЭМТ-тэй хамтран иргэд эмч мэргэжилтэн нарт сургалт явуулж, тараах материал хэвлэж байршуулсан, жоргүйгээр эм олгох асуудлыг эрс багасгаж, антибиотикийг зөвхөн жороор олгож хэвшсэн байна. 2017 оны хяналт шалгалтаар Рашаан сувиллын газрууд нь ЯТТ үзүүлэх эм, эмнэлгийн хэрэгслийн бэлэн байдлыг хангаагүй, эм хүлээн авахдаа дагалдах бичиг баримттай нь тулгаж авдаггүй, эмийн гаж нөлөөг бүртгэдэггүй, илэрсэн үед авч хэрэгжүүлэх зааваргүй байсан зөрчлийг арилгасан, мөн эм био бэлдмэл, эмнэлгийн хэрэгслийг хадгалалтын горимын дагуу хадгалдаггүй, эмнэл зүй, эмнэлгийн ажилтны чиглэлээр шаардлага хангахгүй байсныг тус тус илрүүлж, зөрчлийг арилгасан байна.

ДҮГНЭЛТ:

Аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг гаргаж байна.

Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр, 2017-2019 оны нийгэм, эдийн засгийг хөгжүүлэх үндсэн чиглэлд тусгагдсан аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрөл бүхий байгууллагуудтай холбогдох зорилтын хэрэгжилтүүд хангалтгүй байна.

Тусгай зөвшөөрөл олгоход хураах тэмдэгтийн хураамжийн хэмжээг аймгийн ИТХ тогтоох байтал аймгийн ИТХТ-ийн тогтоолоор баталсан байна.

Түгээмэл тархацтай ашигт малтмал ашиглах, хайх тусгай зөвшөөрөл бүхий компаниуд тайлан мэдээгээ цаг хугацаанд нь холбогдох газарт хүргүүлээгүй байна.

Согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх цэгийн хязгаар тогтоосон эрх зүйн акт нь хүчин төгөлдөр бус байдлаас шалтгаалж аймгийн хэмжээнд согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх аж ахуйн нэгжид олгосон тусгай зөвшөөрлийн тоо жилээс жилд нэмэгдсэн, зөрчил давтан гаргаж буй байгууллагуудын тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлэх үйл ажиллагаа хангалтгүй, цуцалсан зөвшөөрлийг богино хугацаанд эргүүлж олгосон байна.

Тусгай зөвшөөрөл авахад бүрдүүлэх баримт бичгийн бүрдэл, улсын тэмдэгтийн хураамжийн төлбөр тооцоог хянах шаардлагатай байна.

Тамхины хяналтын тухай хуульд “баар, цэнгээний газарт тамхи худалдах”-ыг хориглосон байхад тэмдэгтийн хураамж төлбөрийн хэмжээг тогтоосон ИТХТ-ийн тогтоолын хавсралтад холбогдох заалтыг өөрчлөөгүй байна.

Сайншанд сумаас бусад сумдад тамхи худалдах тусгай зөвшөөрлийн хугацааг 2 жилийн хугацаатайгаар олгож, сунгалт хийсэн нь хууль эрх зүйд нийцэхгүй байна.

Тусгай зөвшөөрөл олгосон байгууллагуудын талаар мэдээллийг ил тод мэдээлэх шаардлагатай байна.

Эрүүл мэндийн чиглэлээр мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгоход баримтлах тэргүүлэх чиглэлд тусгагдаагүй 9 тусгай зөвшөөрөл олгосон байна.

ЭМ-ийн чиглэлээр үйл ажиллагаа явуулахдаа ирүүлсэн төсөлд дурдагдсан мэргэжлийн боловсон хүчнээр хангагдаагүй, ажлын байрыг өөрчилсөн, холбогдох дүгнэлтүүдийг шинэчилж сунгуулаагүй байна.

Тусгай зөвшөөрөл бүхий байгууллагууд тусгай зөвшөөрлийн хугацаанд стандарт дүрэм журмыг мөрдөж ажиллаагүй, хяналтаар өгсөн зөвлөмжийг тууштай хэрэгжүүлж ажиллаагүй байдлаас шалтгаалж мэргэжлийн байгууллагуудын хяналт шалгалтын үр дүн хангалтгүй байхад нөлөөлж байна.

Аудитаар нийт 16.0 сая төгрөгийн зөрчил илрүүлж, 2.1 сая төгрөгийн зөрчлийг аудитын явцад барагдуулсан ба зөрчлийг арилгах 5.0 сая төгрөгийн 5 албан шаардлага бичиж бусад 8.9 сая төгрөгийн зөрчилд холбогдох албан тушаалтанд зөвлөмж хүргүүлээ.

ЗӨВЛӨМЖ:

Аудитын дүн, дүгнэлт нотлох зүйлст үндэслэн дараах зөвлөмжийг өгч байна.Үүнд:

1. Аймгийн Засаг дарга танаа

1. Аж ахуйн үйл ажиллагааны улмаас нийгэмд учрах эрсдэл, бодит хэрэгцээ зэрэг хүчин зүйлийг судалж, хууль эрхзүйн шаардлага хангасан тохиолдолд тусгай зөвшөөрөл олгож байх.
2. Сумын Засаг дарга нарт тамхины хяналтын тухай хуулийг хэрэгжүүлж ажиллах, тамхи худалдах тусгай зөвшөөрлийг 3 жилээр олгох, сунгах, ЕБС-ийн хичээлийн болон дотуур байрнаас 500 метрийн доторх зайг тодорхойлсон зураглалыг сумын ЗДТГ-аар баталгаажуулж ажиллах, сумдад үйл ажиллагаа явуулж буй эрүүл мэндийн чиглэлийн тусгай зөвшөөрөлтэй ААНБ-д хяналт тавьж, мэргэжил аргагүйгээр хангаж ажиллах талаар чиглэл өгч, хяналт тавьж ажиллах.
3. Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрөл олгоход хураах тэмдэгтийн хураамжийн хэмжээг тогтоосон ИТХТ-ийн 2011 оны 09 сарын 14-ний өдрийн 51 дүгээр тогтоолыг хүчингүй болгож, хууль эрхзүйд нийцүүлж шинэчлэн гаргах саналыг аймгийн ИТХ-д оруулах.


2. Аймгийн ЗДТГ-ын ХОХБХ-т

1. Тусгай зөвшөөрөл олгоход бүрдүүлэх баримт бичиг, тэмдэгтийн хураамж төлсөн төлбөрийн баримтыг тусгай зөвшөөрөл авах болон сунгуулахаар хүсэлт ирүүлсэн ААНБ тус бүрээр бүртгэж хянах, төлбөрийг бүрэн төлүүлэх.
2. Ашигт малтмал, газрын тосны газраас ашиглалтын тусгай зөвшөөрөл авсан компаниудын тусгай зөвшөөрлийн төлбөрийг орон нутгийн төсөвт оруулах
3. Засгийн газрын болон орон нутгийн бодлого шийдвэр, хөтөлбөр арга хэмжээний зорилго зорилтууд хэрхэн хангагдаж байгаа мэдээллийг холбогдох төрийн болон хувийн хэвшлийн байгууллагаас авч харилцан уялдаатай ажиллах.
4. ААНБ шинээр худалдаа үйлчилгээний барилга барихад мэргэжлийн зөвлөгөө өгч ажиллах.

3. Эрүүл мэндийн чиглэлээр мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн комисст

1. Эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас баримталж буй тэргүүлэх чиглэлтэй нийцсэн төслийг дэмжих.
2. Тусгай зөвшөөрлийн хугацааг сунгахдаа ажлын байрны чанар, ашиглалтын байдал, эрүүл ахуйн дүгнэлт, галын аюулгүй байдлын дүгнэлтийн хүчинтэй эсэхийг хянах.
3. ЭМСС-ын 2015 оны 298 дугаар тушаалаар баталсан тусгай зөвшөөрлийн үйл ажиллагааны зардлын жишгийн дагуу шинжээчийн ажлын хөлсийг тооцож олгож байх

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ч. АРИУНАА

Холбогдох байгууллагын санал:



**ДОРНОГОВЬ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГА**

44103 Дорноговь аймаг, Сайншанд сум, 3 дугаар баг,
Нутгийн удирдлагын ордон, Утас: 7052 2533,
Факс: (976) 7052 2530, И-мэйл: zdtg@dornogovi.gov.mn,
Вэбсайт: dornogovi.gov.mn

дсд. 06.30 № 2/1051

танай 2020.06.25-ны № _____-т

**ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН
АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА, ТЭРГҮҮН
АУДИТОР Ч.АРИУНАА ТАНАА**

Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 16 дугаар зүйлд заасан дагуу аймаг, сумын Засаг даргаас зөвшөөрөл олгох үйл ажиллагаанд хийсэн нийцлийн аудитын тайланг хүлээн авч танилцан, тайланд дурдагдсан зарим асуудлын талаар тайлбар хүргүүлээ.

Хавсралт: хуудастай.

ЗАСАГ ДАРГЫН
ОРЛОГЧ



Г.ЭРДЭНЭЦЭЦЭГ

44 6201048

СОГТУУРУУЛАХ УНДАА ХУДАЛДАХ, ТҮҮГЭЭР ҮЙЛЧЛЭХ ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛТЭЙ ХОЛБООТОЙ ТАЙЛБАР

2020.06.30

Сайншанд

1. Үйлдвэр худалдааны сайдын 2008 оны 05 дугаар “Норматив тогтоох тухай” тушаал нь захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн санд өнөөдрийг хүртэл бүртгэгдээгүй байна. Аймгийн Засаг даргын орлогч даргын 2015 оны 2/1661 тоот албан бичгээр дээрх тушаалыг хүчинтэй эсэхийг тодруулж өгөхийг Монгол Улсын Хууль зүйн яаманд хүссэн байдаг. Хууль зүйн яамны хууль зүйн нэгдсэн бодлогын газрын дарга Т.Ганбаатарын 2015 оны 6/4048 тоот албан бичгээр дээрх тушаалыг захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн санд бүртгэлгүй байна гэж хариу ирүүлсэн. **Захиргааны ерөнхий хуулийн 67 дугаар зүйлийн 67.2-т “Захиргааны хэм хэмжээний актыг зөвхөн улсын нэгдсэн бүртгэлд бүртгэж, “Захиргааны хэм хэмжээний актын эмхтгэл”-д нийтэлсний дараа хүчин төгөлдөр дагаж мөрдүүлнэ”, 67.3-т “Энэ хуулийн 67.2-т заасан шаардлагыг зөрчсөн тохиолдолд тухайн захиргааны хэм хэмжээний акт эрх зүйн үйлчлэл үзүүлэхгүй бөгөөд биелүүлээгүй иргэн, хуулийн этгээдэд үүрэг, хариуцлага хүлээлгэхгүй” гэж заасан байдаг.**

Уг тайлангийн 7 дугаар хуудас, хүснэгт 4-д тусгагдсан Замын-Үүд сум худалдааны 1, үйлчилгээний 1 цэг байх гэснийг дээрх тушаалаар тооцоход ойролцоогоор худалдаа 10, үйлчилгээ 10 байхаар байна.

2. Аймгийн Засаг даргаас тусгай зөвшөөрөл олгоход аймгийн ИТХ-ын 2011 оны 51 дүгээр тогтоолын хавсралтад заасан дагуу улсын тэмдэгтийн хураамж төлүүлэн бүртгэж **/бүртгэл байнга хөтөлдөг/**, АЗДТГ-ын нягтлан, салбар хариуцсан мэргэжилтэн нар хагас, бүтэн жилээр татвар /Татварын улсын байцаагч н.Гэрэлтугатай тулгалт хийж/-т тайлагнан ажилладаг.

Согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрөлтэй холбоотой гарсан захирамжийн хувийг Мэргэжлийн хяналтын газар, Цагдаагийн газар, Татварын хэлтэс, Стандарт хэмжилзүйн хэлтэс, холбогдох сумдын Засаг дарга нарт хүргүүлдэг.

3. Тусгай зөвшөөрөлтэй газруудыг тусгай зөвшөөрөл анх авсан хугацаанаас хойш ямар нөхцөл, шаардлага зөрчсөн тухай нэгдсэн мэдээллийн сан үүсгэн хөтлөх боломжгүй юм. Аймгийн ИТХ-ын 2017 оны 06/05 дугаар тогтоолын 2.1-т “Холбогдох мэргэжлийн байгууллагуудаас ирүүлсэн санал дүгнэлтийг үндэслэн аж ахуйн нэгжид тусгай зөвшөөрөл олгох, хугацаа сунгах, хүчингүй болгох, түдгэлзүүлэх, сэргээх шийдвэрийг хүсэлт ирүүлснээс хойш 15 хоногийн дотор шийдвэрлэнэ”, 10.2-т “Холбогдох хууль тогтоомж, стандартын шаардлага бүрэн хангаагүй, энэ журам болон тусгай зөвшөөрлийн нөхцөл шаардлагыг зөрчсөн болох нь тогтоогдсон, мэргэжлийн байгууллагын хяналт шалгалтын үндэслэл бүхий санал, дүгнэлт гарсан”, 10.3-т “Хүнсний тухай хуулийн 10, 12 дугаар зүйл, Эрүүл ахуйн тухай хуулийн 7 дугаар зүйлийн холбогдох заалтыг зөрчсөн, зөрчил гаргасан нь батлагдсан” гэж заасан байдаг. Тиймээс мэргэжлийн байгууллагын үндэслэл бүхий *И нотлох баримтаар*

батлагдсан/ санал, дүгнэлтийг үндэслэн тусгай зөвшөөрөл олгох, сунгах, түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгох асуудлыг шийдвэрлэдэг. Өнөөдрийн байдлаар тусгай зөвшөөрлийн бүрдүүлэх материалд холбогдох мэргэжлийн байгууллагаас олгосон гэрчилгээ, албан бичгийг хамт ирүүлж байгаа тул хүнд суртал, чирэгдэл үүсгэхгүй байх үүднээс байгууллага бүрээс тодорхойлолт авахгүйгээр АЗДТГ-аас шаардлагатай тохиолдолд албан бичгээр санал, судалгаа, мэдээлэл авч байна. Сүүлийн жилүүдэд төрийн хүнд суртлыг арилгах бодлогын хүрээнд аливаа тусгай зөвшөөрөл, бусад төрийн үйлчилгээг цахимд шилжүүлж, мэргэжлийн байгууллага бүрээс заавал тодорхойлолт авах шаардлагагүй болж, хувийн хэвшлийн эрх ашгийг хамгаалах, энэ төрлийн зөрчил, дутагдал гарсан тохиолдолд олон нийт хүчтэй эсэргүүцэх болсон. Мөн зөрчил дутагдал нь ноцтой болон тухайн үед шуурхай арилгах боломжтой гэдгээрээ ялгаатай байдаг. Хэрэг, зөрчил нь хөөн хэлэлцэх хугацаатай төдийгүй төрийн албан хаагч /улсын байцаагчийн эрхгүй/ тухайн аж ахуйн нэгжийн гаргасан бүх л зөрчил дутагдлыг бүртгэх, түүнийгээ тусгай зөвшөөрөлтэй холбоотой шийдвэр гаргахад ашиглах нь холбогдох хууль тогтоомжийг зөрчих юм.

Мөн орон нутагт үйл ажиллагаа явуулж байгаа мэргэжлийн байгууллагууд нь тухайн аж ахуйн нэгжүүдийн үйл ажиллагаанд хяналт тавих, зөрчил дутагдлыг нэн даруй таслан зогсоох, арилгуулах, гарсан хэрэг зөрчлийг тухай бүрд бүртгэх, хөөн хэлэлцэх хугацаа дуусах хүртэл хадгалах, дээд шатны байгууллагад тухай бүрд уламжлан шийдвэрлүүлэх чиг үүрэгтэй юм.

ТАЙЛБАР БИЧСЭН:



/Н.БЯМБАЦЭЦЭГ/

Саналд өгсөн тайлбар:

Ирүүлсэн саналд үндэслэн дараах тайлбарыг өгч байна.


1. Бүлэг 1-ийн 1.1.4-т ирүүлсэн саналыг хүлээн авч дүнгийн хэсэгт өөрчлөлт оруулав.
2. Аудитын дүнгийн хэсэгт улсын тэмдэгтийн хураамж төлөлтийг хянаж бүртгэсэн хэдий ч төлбөрөө бүрэн төлөөгүй байхад тусгай зөвшөөрөл олгосон, сунгасан байна, зөвлөмжийн хэсэгт улсын тэмдэгтийн хураамжийг бүрэн төлүүлэх гэж өөрчлөлт орууллаа.
3. Аймгийн ИТХ-ын 2017 оны 06/05 дугаар тогтоолоор баталсан “Согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрөл олгох, хяналт тавих журам”-ын 10.2-т “Холбогдох хууль тогтоомж, стандартын шаардлага бүрэн хангаагүй, энэ журам болон тусгай зөвшөөрлийн нөхцөл шаардлагыг зөрчсөн болох нь тогтоогдсон, мэргэжлийн байгууллагын хяналт шалгалтын үндэслэл бүхий санал, дүгнэлт гарсан” тохиолдолд тусгай зөвшөөрлийг хүчингүй болгоно гэж заасан тул тусгай зөвшөөрөл бүхий байгууллагуудын судалгаа байх нь тохиромжтой бөгөөд энэ нь хууль тогтоомж зөрчсөн асуудал болох үндэслэлгүй юм.

АУДИТЫГ ГҮЙЦЭТГЭСЭН БАГИЙН ГИШҮҮД :

Ахлах аудитор

Аудитор


Гэрээт аудитор



Ц.Лүндэгмаа




Т.Мөнхтогтох



З.Давааням

ХЯНАСАН:

Аудитын менежер



Ч.Хэрлэнчимэг

Аудитын явцад хамтран ажилласанд талархал илэрхийлье.

ТАЙЛАН БАТАЛГААЖУУЛСАН ТУШААЛ:



ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН ТУШААЛ

2020 оны 07 сарын 02 өдөр

Дугаар А/21

Дорноговь аймаг, Сайншанд сум

Нийцлийн аудитын тайлан баталгаажуулах тухай

Төрийн Аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 20 дугаар зүйлийн 20.2, 20.3, 21 дүгээр зүйлийн 21.1, Монгол улсын Ерөнхий аудиторын 2016 оны А/95 тоот тушаал, 2016 оны А/146 тоот тушаалаар батлагдсан "Нийцлийн аудитын түр журам"-ын 9 дүгээр зүйлийн 9.2 дахь заалт, 2018 оны А/207 тоот тушаалын 5 дугаар хавсралтын 2.4 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. "Орон нутагт тусгай зөвшөөрөл олгох үйл ажиллагаанд мөрдөгдөж байгаа дүрэм журмын хэрэгжилт, үр дүн" сэдэвт нийцлийн аудитын тайлан, 01/100 ДГА-2020/02/-НА, 02/101 ДГА-2020/02/-НА, 03/102 ДГА-2020/02/-НА, 04/103 ДГА-2020/02/-НА, 05/104 ДГА-2020/02/-НА дугаар бүхий албан шаардлагыг тус тус баталгаажуулсугай.
2. Аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэх арга хэмжээ авч, үр дүнг 2020 оны 09 дүгээр сарын 15-ны өдрийн дотор ирүүлэхийг аймгийн ЗДТГ, ОНӨГ, ГХБХБГ, Замын-Үүд сумын Захирагчийн ажлын албаны дарга нарт, 12 дугаар сарын 15-ны өдрийн дотор ирүүлэхийг аймгийн ИТХ-ын дарга, аймгийн Засаг дарга, Замын-Үүд сумын засаг дарга нарт тус тус зөвлөсүгэй.
3. Аудитын тайланг аймгийн ИТХ-ын дарга, аймгийн Засаг дарга нарт хүргүүлсүгэй.
4. Албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг аудитын менежер /Ч.Хэрлэнчимэг/-т үүрэг болгосугай.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР

Ч.АРИУНАА

